



Монгол улсын эдийн засгийн тойм

2013 оны 4-р сар



Эдийн засгийн энэхүү тойм нь Монгол улсын эдийн засагт сүүлийн үед гарсан өөрчлөлтүүдийг үнэлэн дүгнэдэг нийтлэл юм. Тэргүүлэх эдийн засагч Чорчинг Гогийн ерөнхий удирдлаган дор Ахлах эдийн засагч Таехүн Лигээр удирдуулсан Эдийн засагч Ш. Алтанцэцэг, Зөвлөх Г. Хандцоож, Эдийн засагч Грегори Смит нарын баг тоймыг бэлтгэв. Мөн түүнчлэн Захид Хаснаин, Мариус Висмантас, Екатерина Михайлова, Ларс Жэссэн нар хувь нэмэр оруулсан. Дэлхийн Банкны Монгол дахь суурин төлөөлөгч Корали Гэвэрс мөн энэхүү тоймыг бэлтгэх ажилд зөвлөгөө өгч, хувь нэмэр оруулсан. Тоймыг бүрэн эхээр нь <http://www.worldbank.org.mn> хаягнаас татаж авах боломжтой. Нэмэлт мэдээлэл авах, санал дүгнэлт өгөх, тодруулага авахыг хүсвэл П. Тинатай холбоо барина уу (tpuntsag@worldbank.org).

Агуулга

Хураангуй тойм	
Хураангуй.....	3
Эдийн засгийн хөгжил ба цаашдын төлөв байдал	7
Бодит салбарт гарсан өөрчлөлт, төлөв байдал	7
Инфляци.....	10
Нэгдсэн төсвийн үр дүнгийн гүйцэтгэл, төлөв байдал.....	13
Гадаад салбар	17
Мөнгө, банкны салбар	23
Цаашид тулгамдаж буй сорилтууд: Эрдэсийн орлогын тогтвортой удирдлагын төлөө	28
Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	33
Хавсралт: Уул уурхайн салбарын төлөв байдал (2013 оны 3-р сар).....	34
Монголын уул уурхай	34
Монгол улсад нөлөөлж буй дэлхийн уул уурхайн чиг хандлага.....	35
Монгол улсад ямар учир холбогдолтой болох тухай	37

График

График 1: ДНБ-ий бодит өсөлт (жилийн, хувь).....	9
График 2: ДНБ-ий өсөлтийн задаргаа, салбараар (нэгж хувь).....	9
График 3: Эдийн засгийн өсөлт дэхь хэрэглээ, хөрөнгө оруулалтын задаргаа (нэгж хувь)	9
График 4: Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн өсөлт, 2005 оны тогтмол үнээр (гурван сарын гулсмал дундаж, хувь)	9
График 5: Улаанбаатар хотын хэрэглээний үнэ (хувь, жилийн өөрчлөлт).....	11
График 6: Хүнсний инфляцийн үндсэн хүчин зүйл (хувь, жилийн өөрчлөлт)	11
График 7: Нэгдсэн төсвийн тэнцэлийн чиг хандлага (ДНБ-д эзлэх хувь).....	16
График 8: Төсвийн орлого, зарлагын чиг хандлага (ДНБ-д эзлэх хувь).....	16
График 9: Эрдэсийн орлогын чиг хандлага (ДНБ-д эзлэх хувь)	16
График 10: Орлогын өөрчлөлт (хувь): 2012 оны гүйцэтгэл, 2013 оны төлөвлөгөөний харьцуулалт	16
График 11: Зарлагын өөрчлөлт (хувь): 2012, 2013 онуудын харьцуулалт.....	16
График 12: Нэгдсэн төсвийн алдагдалын төсөөлөл (ДНБ-д эзлэх хувь)	16
График 13: Урсгал дансны тэнцэл (12 сарын гулсмал нийлбэр, сая ам. доллар).....	19
График 14: Экспорт, импорт (12 сарын гулсмал нийлбэр, сая ам. доллар).....	19
График 15: Нийт экспортын сарын өсөлт (хувь, жилийн өөрчлөлт, төрлөөр).....	19
График 16: Нийт импортын сарын өсөлт (хувь, жилийн өөрчлөлт, төрлөөр).....	19
График 17: Экспортын бүтэц (2012 оны гүйцэтгэл, нийт экспортод эзлэх хувь).....	20
График 18: Импортын бүтэц (2012 оны гүйцэтгэл, нийт импортод эзлэх хувь).....	20

График 19: Гадаадын шууд хөрөнгө оруулалтын сарын цэвэр орох урсгал (сая. доллар).....	22
График 20: Гадаад валютын цэвэр нөөц (тэрбум ам. доллар, хувь).....	22
График 21: Мөнгөний нийлүүлэлт (үлдэгдэлийн өөрчлөлт, хувь).....	24
График 22: Банкны зээл, хадгаламжийн өсөлт (хувь, жилийн өөрчлөлт)	24
График 23: Бодит хүү ба ХҮИ-ийн инфляци (хувь).....	25
График 24: Бодлогын хүү ба банкуудад олгосон Төв банкны зээл (хувь, тэрбум төгрөг).....	25
График 25: Хөрвөх чадварын эрсдэлийн үзүүлэлтүүд (хувь).....	26
График 26: Чанаргүй зээлийн багц, нийт активын харьцаа (хувь).....	26
График 27: Нэгдсэн төсвийн тэнцэл, ДНБ-ий харьцаа (хувь): Чили улсын жишээ.....	31
График 28: Нэгдсэн төсвийн тэнцэл, ДНБ-ий харьцаа (хувь): Ботсвана улсын жишээ	31

Шигтгээ

Шигтгээ 1: Үнийг тогтворжуулах хөтөлбөр.....	12
Шигтгээ 2: Монгол улсын Өрийн удирдлагын стратеги	15
Шигтгээ 3: Эрдэс болон эрдэсийн бус бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээ	19
Шигтгээ 4: Монгол улсын хадгаламжийн даатгалын шинэчлэл	27
Шигтгээ 5: Хоёр улсын талаар товчхон: Эрдэсийн орлогоос хуримтлал амжилттай үүсгэж, ашигласан туршлага	31
Шигтгээ 6: Монгол улсын гол эрдэсийн тархац	31
Шигтгээ 7: Дэлхийн уул уурхайн салбарын үндсэн шинж тэмдэг.....	31
Шигтгээ 8: Гол эрдэс бүтээгдэхүүний үнийн сүүлийн үеийн өөрчлөлт	31

Товчлол

ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ХХС	Хүний хөгжлийн сан
МСХ	Монголын санхүүгийн холбоо
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ОТ	Оюутолгой
ам. долл	АНУ-ын доллар
ТТ	Тавантолгой

Хураангуй

Монгол улсын эдийн засаг 2012 онд 12.3 хувиар өсч, хурдацтай өсөлтөө хадгалан үлдэв. Гэвч БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарсантай холбоотойгоор Монгол улсын нүүрсний экспорт ихээр унаж, эдийн засгийн өсөлт тооцоолж байснаас буурсан байна. Хамгийн мэдэгдэхүйц өөрчлөлт гэвэл Монгол улсын төсвийн нийт тэнцэл ДНБ-ий 8.4 хувьд хүрсэн нь сүүлийн 13 жилийн түүхэнд байгаагүй өндөр үзүүлэлт болов. Эдийн засгийн өсөлт хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дахин ихээр хуримтлагдаж байгаа энэ үед төсвийн үр дүнгийн гүйцэтгэл 2013 онд өмнөх оныхтой адил гарч болзошгүй байна. Монгол улс түүхэндээ байгаагүй их дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийж байгаагийн зарим хэсгийг олон улсын захаас анх удаа амжилттай босгосон Чингис бондын хөрөнгөөр санхүүжүүлэх боломж бүрдсэн энэ үед дараах зүйлд анхаарлаа түлхүү хандуулах нь зүйтэй. Үүнд: (1) нийгэм, эдийн засгийн өгөөжийг дээд түвшинд хүргэж, улсын хөрөнгийг үр ашиггүй зарцуулахаас зайслхийх зорилгоор хөрөнгө оруулалтын бэлтгэл ажлыг сайтар хангах, (2) эдгээр төслүүдийн санхүүжилтийг нэгдсэн төсөвт ил тод тусгаж харуулах.

Бодит салбарт гарсан өөрчлөлт, цаашдын төлөв байдал

Монгол улсын эдийн засгийн өсөлт 2012 онд саарсан хэдий ч хоёр оронтой тоогоор илэрхийлэгдсэн хэвээр байв. 2011 онд 17.5 хувьтай байсан эдийн засгийн өсөлт 2012 онд саарч, 12.3 хувь болж буурсан. Эрдэсийн экспорт сайнгүй байсан хэдий ч хөдөө аж ахуйн салбар сэргэж, барилга, тээврийн салбарууд тогтвортой өссөний үр дүнд эрдэсийн бус салбарын гүйцэтгэл өндөр гарч, эдийн засгийн өсөлтийг хоёр оронтой тоогоор илэрхийллээ. 2013 он гарсаар боловсруулах салбар өндөр өсөлттэй байгаа боловч нүүрсний үйлдвэрлэл хумигдаж байгаагаас аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл саарч байна.

Дэлхийн Банк суурь хувилбараа өөрчилж, Монгол улсын эдийн засгийг 2013 онд 13 хувиар өсөхөөр тооцож байгаа ч гэсэн энэ нь дэлхийн хэмжээнд хамгийн өндөр түвшингүүдийн нэг хэвээр байна. Гэхдээ өсөлтийн гол хүчин зүйлүүдийн хувьд тодорхойгүй байдал давамгайлж байгаагаас эдийн засгийн төлөв байдал нэлээд тогтворгүй байна. Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг бууруулж гаргасан нь сүүлийн үед экспортын өсөлт саарч, гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал огцом багасан, БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт нэгдүгээр улиралд удаашралтай байсантай холбоотой юм. Оюутолгой төслийн үйлдвэрлэл нэмэгдсэнээр эрдэсийн үйлдвэрлэл энэ зунаас үлэмж өсөхөөр байгаа бөгөөд Оюутолгойн олборлолт хойшлох буюу тасалдах нь томоохон сөрөг үр дагавартай байх болно. Эдийн засгийн өсөлтийн төлөв байдлыг тодорхой бус болгож буй өөр нэг хүчин зүйл нь Чингис бондын хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн улсын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд юм. Бондын хөрөнгийг ашиглан хэрэгжүүлэх томоохон төслүүдийн хувьд төлөвлөлтийн бэлтгэл ажлыг хангаж, техник эдийн засгийн үнэлгээ хийхэд хугацаа шаардлагатай байгаа тул их хэмжээний хөрөнгө оруулалт түрүүлж гарах магадлал бага байна. Өсөлтийн хурдац эдийн засгийн үйлдвэрлэх хүчин чадлаас түрүүлж байгаа учраас Чингис бондын эх үүсвэрээр улсын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэмж санхүүжүүлэх нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг шахаж, эдийн засгийн өсөлтөд үзүүлэх үр нөлөө нь хязгаарлагдахын зэрэгцээ инфляцийн дарамт үүсгэж болзошгүй юм.

Инфляци 2012 оноос хойш хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэж байсан бол 2013 оны 3-р сард 9.8 хувь болж саарав. Мөнгөний бодлого богино хугацааны зээлийн хүүг бууруулах замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих горимд шилжиж, төсвийн бодлогын тэлэлт үргэлжилж байгаа энэ нөхцөлд инфляци ийнхүү буурсан явдал он дуустал үргэлжлэх эсэх нь тодорхойгүй юм.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, цаашдын төлөв байдал

Нэгдсэн төсвийн алдагдал 2012 онд ДНБ-ий 8.4 хувь болж, сүүлийн 13 жилд байгаагүй өндөр үзүүлэлтэнд хүрсэн нь төсвийн тэнцлийг доройтуулав. Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө 12.1 хувиар тасарч, урсгал зарлага нэмэгдсэний улмаас нийт зарлага санхүүжилтийн өсөлт буураагүй. Нэгдүгээр улиралд хөрөнгө

оруулалтын зарлага санхүүжилт төлөвлөгөөнөөс дутуу хийгдсэн нь орлогын төлөвлөгөө тасарсныг нөхөж, мөн хэт шахуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хүчин чадал хүрэлцэхгүй байгаагийн илрэл боллоо. Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн эдийн засгийн үр ашиггүй төслүүд одоогоор төсвөөс гадуур байгаа бөгөөд эдгээрийн өртгийг оролцуулж тооцвол нэгдсэн төсвийн нийт тэнцэл ДНБ-ий 10.4 хувьд хүрэхээр байлаа.

2013 онд нэгдсэн төсвийн төлөв байдал өмнөх оныхтой төстэй байхаар байна; төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу ДНБ-ий 2 хувиас хэтрэх ёсгүй боловч 7 хувиас давах магадлалтай байна. Нэгдсэн төсвийн орлогын энэ оны төсөөллийг гаргахдаа 2012 оны хэт өндөр төлөвлөгөөн дээр үндэслэсэн бөгөөд энэ удаа орлогыг дахин 15-20 хувиар өндөр тооцоолсон байх магадлалтай юм. 2013 оны эхний гурван сарын орлогын гүйцэтгэлийн мэдээ энэхүү хүлээлтийг баталж байгаа нь харамсалтай юм: өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт орлого дөнгөж 5.8 хувиар өссөн бөгөөд төлөвлөгөөний дагуу оны эцэст 47 хувиар өсөх ёстой. Мөн түүнчлэн, ОТ төслийн хөрөнгө оруулалтын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, хөрөнгө оруулагчдаас 445 тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэр төсөвт оруулахаар төлөвлөсөн ч энэ удаа хэрэгжихгүй бололтой. Дэлхийн Банкны хийсэн тооцооллоор орлого тасарсны улмаас нэгдсэн төсвийн нийт алдагдал ДНБ-ий 6 хувьд хүрэх төлөвтэй байна. Орлого тасрах учраас төсвийн урсгал зарлагын санхүүжилт 5 хувиар дутуу хийгдэнэ гэсэн нөхцлийг энэхүү тооцоололд оруулав.

Төсвийн төлөв байдал хэврэг байхын хажуугаар Үнийг тогтворжуулах хөтөлбөр болон Хөгжлийн банк хэмээх төсвийн гадуурх хоёр эх үүсвэрээс нийгмийн чанартай төслүүдэд санхүүжилт хийгдэх болно. Мөн Чингис бондын хөрөнгийг зарцуулна. Эдгээр эх үүсвэрийг төсөвт тусгаж харуулбал нэгдсэн төсвийн нийт алдагдал ДНБ-ий 13 орчим хувьд хүрэх болно. Тодруулбал, Засгийн газар олон улсын зах дээр зээллэг хийж, Чингис бондын хөрөнгийг босгосон бөгөөд энэ эх үүсвэрийг ашиглаж эхэлснээр төсвийн томоохон ачаалал үүсч, эдийн засагт нөлөөлөл бий болно. Иймд бондын хөрөнгийн ашиглалтыг төсвөөс гадуур бус, төсвийн зарлага дээр зохих байдлаар тусгаж харуулах нь зүйтэй.

Гадаад салбар

Гадаад худалдааны тэнцэл 2013 оны эхний саруудад ерөнхийдөө доогуур байж, эрдэсийн экспорт сайжрахын хирээр оны сүүлийн хагаст нэмэгдэх төлөвтэй байна. Төсвийн зарлага санхүүжилт оргилон, дотоодын эрэлт өсөн нэмэгдэж, гадаад салбарын тэнцвэргүй байдал 2012 онд түүхэндээ байгаагүй өндөр түвшинд хүрч, урсгал дансны алдагдал 3.2 тэрбум ам. доллар болж, ДНБ-ий 31.3 хувьтай тэнцсэн. Өнгөрсөн онд нүүрсний экспорт огцом унасны улмаас нийт экспорт 9 хувиар буурсан бол импорт 2.1 хувиар өсчээ. Нүүрсний экспортыг дагаж нийт экспорт 2013 онд буурч, гадаад худалдааны тэнцэл ихээхэн алдагдалтай хэвээр байх төлөвтэй байна. Мөн импортын өсөлт эхний улиралд сөрөг утгатай болов. ОТ төслийн үйлдвэрлэл явагдаж, зэсийн экспорт нэмэгдсэнээр нийт экспорт оны сүүлийн хагаст өсөх тооцоотой байна. Харин ОТ бүтээн байгуулалттай холбоотой импорт бага байх учраас нийт импорт оны туршид нэг их өсөхгүй байх болно.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал огцом буурсан нь эдийн засгийн өсөлтийг доош нь чангаах томоохон эрсдэл болж байна. 2011 онд 4.6 тэрбум ам. долларт хүрч байсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал 2012 онд 17 хувиар буурч, 3.8 тэрбум ам. доллар болсон. 2013 оны эхний хоёр сарын байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал эрс багассан: өмнөх оны мөн үеийн хэмжээтэй харьцуулахад дөнгөж 42 хувьтай тэнцэж байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал ийнхүү огцом буурсан нь ОТ бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт багасч байгаагаас гадна Монгол улсын хөрөнгө оруулалтын орчны талаар гадаадын хөрөнгө оруулагчид хаширлаж байгаагийн дохио болж байна. Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль 2012 оны 6-р сард батлагдаж, Засгийн газар хөрөнгө оруулалтын зарим гэрээнүүдийг эргэн харж эхэлсэн. Бүрэн төлөвшсөн хөрөнгийн зах дотоодод байхгүй, олон улсын хөрөнгийн захаас хөрөнгө босгох нөхцөл боломж хязгаарлагдмал учраас гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал огцом багасах нь эдийн засагт томоохон үр дагавартай юм. Сүүлийн хоёр жилийн хугацаанд Монгол улсад хийгдсэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын ихэнх хэсэг нь гадаадын шууд хөрөнгө оруулалт байсан юм.

Мөнгө, банкны салбар

Эдийн засгийн өсөлт 2012 онд саарч, банкуудын зээлийн өсөлт буурсан тул мөнгөний бодлого 2013 оны эхэн үеэс богино хугацааны зээлийн хүүг бууруулах замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих чиглэлтэй болсон. Хоёр жилийн хугацаанд мөнгөний хатуу бодлого баримталсан Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2013 оны эхний улиралд бодлогын хүүнд хоёр удаа өөрчлөлт оруулав. Тухайлбал, 1-р сард 13.25 хувиас 12.5 хувь болгосон бол 4-р сарын эхээр 11.5 хувь болгож дахин бууруулсан. Бодлогын хүүг бууруулахтай зэрэгцээд Монголбанк Үнийг тогтворжуулах хөтөлбөр хэрэгжүүлж, арилжааны банкуудад 12 сарын хугацаатай хадгаламж байршуулах замаар эдийн засагт шинэхэн нөөц мөнгө нийлүүлж байна. Инфляцийн ерөнхий үзүүлэлт 2013 оны 3-р сард нэг оронтой тоо руу орж буурсан хэдий ч улам бүр суларч байгаа мөнгөний бодлого нийт эрэлтийг дэмжин, инфляцийн дарамтыг өсгөж болзошгүй юм. Иймд мөнгөний бодлогыг сулруулж байгаа нь инфляцид хэрхэн нөлөөлж байгааг нягт ажиглах нь зүйтэй.

Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд санхүүгийн тогтвортой бус байдал заналхийлж байгаагийн дохио харагдахгүй байна. Хөрөнгийн захын хөгжил хоцрогдож, цөөн хэдэн томоохон банкуудын зээл аж ахуйн нэгж, иргэдийн санхүүжилтийн гол арга хэрэгсэл болж байна. 2012 онд арилжааны дөрвөн банк салбарын нийт зээлийн багцын 75 хувийг бүрдүүлж байсан. Тухайлбал, Хаан банк - 25.2 хувь, Худалдаа хөгжлийн банк - 21.8 хувь, Голомт банк - 20.5 хувь, ХасБанк – 9 хувь. Томоохон банкууд санхүүгийн салбарт чухал ач холбогдолтой байгаа учраас банкны системийн тогтвортой байдалд байнгын мониторинг хийж, хяналт шалгалт явуулж байх нь чухал байна.

Цаашид тулгарч буй сорилтууд: Эрдэсийн орлогыг тогтвортой удирдахын төлөө

Төсвийн бодлого байнга тэлж, мөчлөг дагасан шинжтэй байгаа нь эдийн засаг тууштай, тогтвортой өсөхөд эрсдэл болсон хэвээр байна. 2008-2009 оны санхүү эдийн засгийн хямралаас олж авсан сургамжид үндэслэн УИХ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг 2010 онд баталж, төсвийн зарлага санхүүжилтийг цаг хугацаанд жигд хуваарилах тогтолцоог бүрдүүлсэн. Гэвч Монгол улсын төр засгаас хэрэгжүүлж буй төсвийн бодлого хямралын өмнөх шиг дахин мөчлөг дагасан шинжтэй болж ирлээ. Зэсийн зах зээл гэнэт сүйрэхэд мөчлөг дагасан төсвийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжгүй гэдэг нь нэгэнт батлагдсан билээ. Төсвийн алдагдал ихээр хуримтлагдаж эхэлсэн энэ үед эрдэс бүтээгдэхүүний зах зээл дээр гэнэтийн цочрол үүссэн тохиолдолд төсвийн бодлогын эрх бүхий байгууллага асуудлыг зохицуулан шийдвэрлэх нөхцөл боломж тун хязгаарлагдмал байх болно. Төсвийн орлогыг тасалдуулах цочрол бий болсон нөхцөлд төсөвт жийрэг болж өгөх учиртай хуримтлал хангалттай бүрдээгүй байна. Төсвийн орлого тасарч, зарлага санхүүжилтийг танаж зохицуулах амаргүй шийдвэр гаргах шаардлага үүсэх бөгөөд энэ нь эргээд эдийн засгийг улам хумих болно.

Сүүлийн арван жилд 35 дахин нэмэгдсэн хөрөнгө оруулалтын зардал хурдацтай өсч байгаа нь шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний чанарыг муутгах эрсдэл агуулж байна. Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын тогтолцоо, барилгын салбарын шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийг шингээх хүчин чадлыг тэр бүр хурдан нэмэгдүүлж чадахгүй. Төслийн үнэлгээ, худалдан авалт хийх, гэрээ хэлцэл байгуулах, хяналт тавих байгууллагууд одоогоор хөгжин бэхжиж байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын төсөв хурдацтай нэмэгдэж байгаагаас тэдний хүчин чадал хүрэлцэхгүй байна. Үүний улмаас төсөл, арга хэмжээний чанар доройтож байна. Төсвийн зарлага санхүүжилт эдийн засгийн үйлдвэрлэх хүчин чадлын өсөлтөөс давсан хурдаар нэмэгдэж байна. Монгол улс бол ажиллах хүч, завсрын бүтээгдэхүүний (жишээлбэл, барилгын материал) хязгаарлагдмал нөөцтэй, нээлттэй жижиг эдийн засагтай орон юм. Улсын хөрөнгө оруулалт эдийн засгийн үйлдвэрлэх хүчин чадлаас давж, хурдацтай нэмэгдэхийн хирээр мэргэжилтэй ажиллах хүч, үйлдвэрлэлийн бусад хүчин зүйлсийн нийлүүлэлт хангалтгүй байх учраас үйлдвэрлэлийн өртгийг өсгөж, инфляцийг хөөрөгдөж, улсын хөрөнгө оруулалтын чанарыг муутгах талтай байдаг.

Төсвийн удирдлагын загвар одоогоор “хурдан зарцуулах”-д чиглэж байгааг болиулж, “үр ашигтай зарцуулах” болгон өөрчлөх зөвшилцөлд хүрэх нь өнөөдрийн томоохон сорилт болоод байна. Үүний тулд төсвийн зохицуулалтыг илүү оновчтой, ухаалаг болгож, урьдын тэлэлт, агшилтын мөчлөг дахин давтагдахаас сэргийлэн, засгийн газрын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр ашигтай хэрэгжүүлэх чадавхи, эдийн

засгийн шингээх хүчин чадалд нийцүүлэн төсвийн зарлага санхүүжилтийн өсөлтийг тогтоох хэрэгтэй. Төсвийн зарлага санхүүжилт эрдэсийн орлогын богино хугацааны хэлбэлзлээс аль болох ангид байлгах ёстой. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон тусгай шаардлагуудыг хангаж, төсвөөс гадуурх санхүүжилтийн механизм ашиглахгүй байх нь ойрын хугацаанд хийж гүйцэтгэх ажил юм. Төсвийн алдагдалыг бууруулах зөв зүйтэй төлөвлөгөө гарган ажиллаж, 2013 онд төсвийн алдагдалыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд заасан хязгаарт багтаах нь зүйтэй.

“Төсвийг оновчтой зарцуулах” гэдэг нь эрдэс баялгийн нөөцийг Монгол улсын одоогийн болоод шинээр төрөх иргэдийн аж байдлыг сайжруулахад үр дүнтэй зориулж, зарим нөөцийг ашиглан урьдчилан сэргийлэх зорилготой хуримтлал үүсгэх явдал юм. Эрдэсийн орлого маш их хэлбэлзэж, урьдчилан тооцох боломжгүй байдаг учраас Монгол улсын эдийн засагт эрдэс бүтээгдэхүүний зах зээл гэнэт сүйрэх эрсдэл хэзээд нүүрлэж байдаг. Төсвийн зохицуулалтын хүрээнд хуримтлалын тогтолцоо бий болгоход тулгарах гол бэрхшээл нь орж ирж байгаа орлогыг одоо зарцуулж, эрдэс баялгаас ногдол ашиг хүртэх хүлээлтийг өдрөөс өдөрт өсгөх гэсэн улс төрийн дарамт шахалтыг даван туулах явдал байх болно. Урьдчилан сэргийлэх хуримтлал бүрдүүлэх нь мөн орлого багатай иргэдийг дэмжсэн, хөгжлийн үр ашигтай стратеги байдаг. Орлого багатай, эмзэг бүлгийн иргэдийг дэмжсэн нийгмийн халамжийн тогтолцоог бэхжүүлэхийн зэрэгцээ эдийн засагт нэлээд том уналт нүүрлэсэн үед төсвийн хөгжилд чиглэсэн зарлага санхүүжилтийг бууруулахгүй байхад төсвийн хуримтлалыг ашиглах боломжтой байдаг.

Эдийн засгийн хөгжил ба цаашдын төлөв байдал

Бодит салбарт гарсан өөрчлөлт, төлөв байдал

Монгол улсын эдийн засгийн өсөлт 2012 онд саарсан ч хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэх үзүүлэлттэй хэвээр байв. 2011 онд 17.5 хувиар өсч байсан эдийн засаг 2012 онд 12.3 хувиар тэлж, өсөлтийн хурдац саарлаа (График 1). Эдийн засаг 2012 оны эхний хагаст өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.5 хувиар өссөн бол БНХАУ-ын Монголоос авах эрдэсийн экспортын эрэлт багассанаас сүүлийн хагаст өсөлт 10.6 хувь болж буурсан. Эрдэсийн экспортын өсөлт саарсан хэдий ч хөдөө аж ахуйн салбар сэргэж, барилга, тээвэр, мэдээлэл харилцаа холбооны салбарууд тогтвортой өссөний үр дүнд эрдэсийн бус салбарын гүйцэтгэл өндөр гарч, эдийн засгий нийт өсөлтийг хоёр оронтой тоогоор илэрхийлэв (График 2).

Уул уурхай, олборлох салбарыг хасч тооцсон эрдэсийн бус ДНБ 2011 онд 19.7 хувийн өсөлттэй байсан бол 2012 онд 12.9 хувийн өсөлттэй болж буурсан. Бөөний болон жижиглэн худалдааны салбар өсөлт муутай байсан боловч хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн сэргэлт эдийн засгийн өсөлтийг хоёр оронтой тоонд хадгалж үлдэхэд чухал үүрэг гүйцэтгэв.

- **Хөдөө аж ахуйн салбар 2011 онд 0.5 хувийн уналттай байсан бол 2012 онд 21.3 хувиар өслөө.** Газар тариалан эрчимтэй өсч, малын тоо толгой өмнөх зүй бус хорогдлоо нөхөж чадсан нь эдийн засгийн нийт өсөлтийн дөрөвний нэгийг бүрдүүлсэн энэ салбарын өсөлтийг бий болгов. 2009-2010 оны өвөл тохиолдсон хахир зудын уршгаар нийт малын тавны нэгтэй тэнцэх тооны мал зүй бусаар хорогдсон юм. Зудын улмаас хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 2010 онд 16 гаруй хувиар унасан хэдий ч тус салбарт гарсан сүүлийн үеийн өсөлтийн ачаар малын тоо толгой эргээд 40.9 саяд хүрч, мал аж ахуйн салбар 2012 онд 12.6 хувиар өссөн. Цаг агаарын байдал тааламжтай байсан тул үр тарианы ургац хураалт ч мөн 2012 онд өсч, 12.6 хувийн өсөлттэй гарав.
- **Боловсруулах, тээврийн салбарын үйл ажиллагааны үр дүн тогтвортой сайн байж, барилгын салбар хурдацтай өсөв.** Боловсруулах салбарын өсөлт 2011 онд 7.3 хувь байсан бол 2012 онд 8.9 хувьд хүрсэн нь хүнс, согтууруулах бус ундааны үйлдвэрлэл нэмэгдсэнтэй үндсэндээ холбоотой байлаа. Төсвийн хөрөнгө санхүүжилтээр дэд бүтцийн төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалт үргэлжилсэн тул барилгын салбар 2012 онд 25.6 хувиар өсөв. Үйлдвэрлэл үйлчилгээ, орон сууцны зориулалттай барилга үйлдвэрлэл 2011 онтой харьцуулахад нэлээд буурсан хэдий ч төсвийн санхүүжилттэй барилгын ажлууд, түүний дотор сургууль, эмнэлэг зэрэг нийтийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийн хөрөнгө оруулалт нэмэгдсэн тул нөхөж чадсан. Тээврийн салбар өмнөх онд 9.1 хувиар өссөн бол 2012 онд үйл ажиллагаа нь 12.8 хувиар тэлжээ. Бөөний болон жижиглэнгийн худалдааны эргэлт 2011 онд 38.3 хувийн өсөлттэй байсан бол 2012 онд 10.3 хувийн үзүүлэлттэй болж буурчээ.

Нүүрс олборлолт буурсан хэдий ч уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлт дундаж хэмжээнд хадгалагдаж, 2012 онд 8.9 хувийн үзүүлэлттэй гарав. 2011 онд энэ салбар 7.3 хувийн өсөлттэй байсан юм.

- БНХАУ-ын аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2012 оны хоёрдугаар хагаст буурч, Монголын нүүрс олборлолт 2011 онд 30.9 сая тонн байсан бол 2012 онд 7.7 хувиар багасч, 28.6 сая тонн болж буурав. 2012 онд нүүрсний олборлолт эрдэсийн ДНБ-ий 30 орчим хувийг бүрдүүлж, олборлолтын 86 хувийг нь экспортлосон байна.

- Газрын тосны олборлолтын цооног шинээр нэмэгдэж, 2012 онд олборлолт 42.6 хувиар огцом өсч, 3.6 сая баррельд хүрэв. Газрын тосны олборлолт 2012 онд эрдэсийн ДНБ-ийн 15.4 хувийг бүрдүүлж, бүгд БНХАУ уруу экспортлогдсон.
- Алтны олборлолт 2011 онд буурсан байсан бөгөөд 2012 онд 5.1 хувиар өссөн нь маргаан дагуулсан зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн гэнэтийн ашгийн татвар хүчингүй болсонтой зарим талаар холбоотой юм. Төмрийн хүдрийн олборлолт 2012 онд 30 гаруй хувиар өссөн бол зэсийн үйлдвэрлэл 2011 оны хэмжээнээс өөрчлөгдсөнгүй. ОТ уурхайн олборлолтын эхний үе шат буюу ил уурхайн олборлолт энэ оны дундуур эхлэхээр төлөвлөгдсөн байгаа тул зэсийн үйлдвэрлэл 2013 оноос үлэмж нэмэгдэх учиртай.

Нийт эдийн засгийн үйлдвэрлэлд эрдэсийн ДНБ-ий эзлэх хувь хэмжээ 2009 оноос байнга багасч ирсэн бөгөөд 2012 оны байдлаар 15.7 хувь болсон. Уул уурхайн үйлдвэрлэл сүүлийн хоёр жилд 7-8 хувийн өсөлттэй байсан хэдий ч уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой барилга, тээвэр, бусад үйлчилгээ эрчимтэй өсч, уул уурхайн өсөлтөөс түрүүлэх болсон. ОТ уурхайн зэс, алтны олборлолт төлөвлөгөөний дагуу явагдах тохиолдолд эрдэсийн үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2013 оноос үлэмж нэмэгдэх төлөвтэй байна.

Ашиглалтын аргаар тооцож үзвэл, хэрэглээ, хөрөнгө оруулалт хоёулаа хоёр оронтой тоогоор илэрхийлэгдсэн өсөлтийг тэтгэсэн бөгөөд хөрөнгө оруулалтын өсөлт бага зэрэг саарч, гадаад худалдааны алдагдал нэмэгдсэн нь эдийн засгийн тэлэлтийг тодорхой хэмжээгээр хязгаарласан байна (График 3). Эцсийн хэрэглээ 2012 онд өмнөх оноос 18 хувиар өсч, оны туршид 17-20 хувийн тогтвортой өсөлттэй байв. Сургалтын төлбөрийн тэтгэлэг, иргэн бүрт бэлнээр олгосон хувь хишиг, жижиг дунд үйлдвэрийн зээл, ноос, ноолуурын урамшуулал зэргээр засгийн газрын хэрэглээ өссөн нь эцсийн хэрэглээний өсөлтийн гол шалтгаан байв¹. Хөрөнгө оруулалтын зардлын өсөлт өндөр түвшинд хадгалагдаж, 24 хувь байсан. Гэхдээ хөрөнгө оруулалт 2012 оны эхний улиралд 68 хувиар өсч байсан бол эцсийн улиралд 16.3 хувь болж нэлээд саарсан нь дотоодын хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг сүүлийн үед ихээр дэмжиж байсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал багассантай холбоотой юм. Хөрөнгө оруулалт буурахтай зэрэгцээд машин, тоног төхөөрөмжийн импорт 2012 оны сүүлийн хагаст огцом хумигдаж, дөрөвдүгээр улиралд бүр сөрөг өсөлттэй гарсан.

Боловсруулах салбарын үйлдвэрлэл хурдацтай өсч байгаа хэдий ч нүүрсний олборлолт буурч байгаагаас аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн өсөлт 2013 оны эхний улиралд саарч байна. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн өсөлт нэгдүгээр сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16 хувьтай байсан бол 3-р сард хоёр хувьтай болж, гурван сар дараалан буурлаа. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл хумигдаж байгаагийн гол шалтгаан нь нүүрсний олборлолт буурч байгаа явдал юм. Нэгдүгээр сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.9 хувийн өсөлттэй байсан нүүрс олборлолт гуравдугаар сард 32.2 хувийн уналттай гарч, нүүрсний нийт олборлолт эхний улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.2 хувиар багасчээ. Харин боловсруулах салбарын үйлдвэрлэл эрчимтэй явагдаж, эхний улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32 хувиар өссөн. Оёмол, нэхмэл, сүлжмэл бараа, резин, хуванцар бүтээгдэхүүн, арьс ширний үйлдвэрлэл хурдацтай нэмэгдэж байна. Хэрвээ нүүрс олборлолт удаан хугацаанд сэргэж чадахгүй бол аж үйлдвэрийн салбарын гүйцэтгэл энэ онд тааруу гарах төлөвтэй байна. Үүний зэрэгцээ БНХАУ-ын эдийн засаг эхний улирлын байдлаар бууралттай гарсан нь онцгойлон нөлөөлж болзошгүй юм.

¹ Иргэн бүрт олгосон хувь хишиг нь нэг сая төгрөг байсан бөгөөд үүнийг сар бүр 21 мянган төгрөгөөр хувааж олгосон. Мөн их дээд сургуулийн оюутнууд сар бүр 70 мянган төгрөгийн амьжиргааны тэтгэлэг авч байна. УИХ-аас 2011 онд баталсан 30-р тогтоолын дагуу Засгийн газар 300 тэрбум төгрөгийн бонд гаргаж, ЖДҮ-үүдэд хөнгөлөлттэй зээл олгосон.

ДНБ-ий бодит өсөлт саарчсан ч хоёр оронтой тоогоор илэрхийлэгдсэн хэвээр байна.

График 1: ДНБ-ий бодит өсөлт (жилийн, хувь)




Хөдөө аж ахуй, барилгын салбар өсөлтийг хоёр оронтой тоогоор илэрхийлэх түлхэц болсон бол харин уул уурхайн салбарын өсөлт дунд зэрэг байв.

График 2: ДНБ-ий өсөлтийн задаргаа, салбараар (нэгж хувь)



Хөрөнгө оруулалтын өсөлт саарсан ч хэрэглээ нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлтийг 2012 онд дэмжив.

График 3: Эдийн засгийн өсөлт дэхь хэрэглээ, хөрөнгө оруулалтын задаргаа (нэг хувь)



Боловсруулах салбарын үйлдвэрлэл өсч байгаа хэдий ч нүүрсний экспорт буурснаас аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2013 онд саарч байна.

График 4: Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, 2005 оны тогтмол үнээр (3 сарын гулсмал нийлбэр, хувь)



Эх сурвалж: УСХ, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоолол.

Дэлхийн Банк өөрийн гаргасан Монгол улсын эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллийг 2013 онд 13 хувь болгож өөрчилсөн нь дэлхийн хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлтүүдийн нэг хэвээр байна. Гэхдээ эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйлүүдийн хувьд тодорхойгүй байдал нэлээд давамгайлж байгаа учраас цаашдын төлөв байдлыг маш их тогтворгүй болгож байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал, нүүрсний экспорт сүүлийн үед багассан, БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт удаан явагдаж байгаа тул төсөөллийг өөрчилсөн. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт өнгөрсөн оны дөрөвдүгээр улиралд 7.9 хувьтай байсан бол энэ оны эхний улиралд 7.7 хувь болж саарсан. Иймд Монгол улсын эдийн засгийн өсөлтийн энэ оны төлөв байдал дараах хүчин зүйлүүдийн хувьд бий болсон байгаа тодорхой бус байдал хэрхэн өрнөхөөс ихээхэн хамаарах болно. Үүнд:

- **ОТ төслийн олборлолт, борлуулалт.** Уг төслийн зэс, алтны олборлолт төлөвлөгөөний дагуу хоёрдугаар улиралд эхэлж чадвал эрдэсийн үйлдвэрлэл 2013 онд 30-40 хувьд хүрч өсөх болно. ОТ уурхайн олборлолт аажмаар нэмэгдэж, 2021 оны үед бүрэн хүчин чадалдаа хүрэх тул төслийн эдийн засгийн өсөлтөнд оруулах хувь нэмэр дунд болон урт хугацаанд улам бүр нэмэгдэх болно. Дэлхийн

Банкны гаргасан суурь төсөөлөлд ОТ уурхайн олборлолт төлөвлөгөөний дагуу явагдана гэж тооцсон. Гэвч уурхайн олборлолт ямар нэгэн байдлаар хойшлох буюу тасалдах нь 2013 он болон түүнээс хойшхи хугацааны эдийн засгийн өсөлтөнд сөргөөр нөлөөлөх болно.

- **Нүүрс олборлолт өмнөх хэмжээндээ очиж сэргэх.** БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн хурдац ойрын үед буцаж нэмэгдвэл нүүрс олборлолт 2012 оны буурсан хэмжээнээсээ аажмаар өсч, өмнөх түвшиндээ эргэн очих боломжтой. Гэхдээ нүүрс олборлолт буурсан, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт нэгдүгээр улиралд тооцоолж байснаас доогуур гарсан тул нүүрс олборлолт, экспорт хэзээ, ямар хурдацаар сэргээх нь тодорхой бус хэвээр байгаа бөгөөд энэ нь эдийн засгийн төлөв байдлыг доош нь чангаах эрсдэл болж байна.
- **Улсын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ шинээр нэмж хэрэгжүүлэх.** Чингис бондын 1.5 тэрбум ам. долларын хөрөнгийг ашиглан хөрөнгө оруулалтын томоохон төслүүд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. ДНБ-ий 12 хувьтай тэнцэх бондын хөрөнгийг ашиглаж эхэлсэнээр эдийн засагт томоохон үр дагавар авчирна. Бондын хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийн тухайд төлөвлөлт хийж, техник эдийн засгийн үндэслэлийг үнэлэхэд хугацаа шаардлагатай тул хөрөнгийн нэлээд хэсгийг энэ ондоо багтааж зарцуулж амжихгүй болов уу. Төслийн техник эдийн засгийн үндэслэлийг тогтоолгүйгээр томоохон хөрөнгө оруулалтын төслийн хөрөнгийн ихэнх хэсгийг эхний шатанд зарцуулах, эдийн засгийн шингээх хүчин чадал хязгаарлагмал байгаа нь төслийн эдийн засгийн өсөлтөнд үзүүлэх эерэг үр нөлөөг хязгаарлаад зогсохгүй эдийн засагт хэт халалтын дарамтыг бий болгоно.

Инфляци

Инфляци 2012 он гарсаар буурах хандлага ажиглагдаж байна. 2012 оны туршид хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэж байсан үнийн өсөлт гуравдугаар сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэг оронтой тоонд орсон (График 5). 2012 оны 12-р сард улсын ХҮИ-ийн жилийн өсөлт 14.0 хувьтай гарч, Монголбанкнаас тогтоосон зорилтот түвшин болох нэг оронтой тооноос давж гарсан. 2013 он гарсаар инфляци буурч, хоёрдугаар сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.3 хувь, гуравдугаар сард 9.8 хувь болсон. Сүүлийн сард инфляци ийнхүү буурсан нь мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт нэлээд саарсантай холбоотой байлаа. Хүнс, эрчим хүч гэсэн өөрчлөлт ихтэй үнийг хасч тооцсон суурь инфляци нэгдүгээр сард 10.5 хувь байсан бол гуравдугаар сард 9.6 хувьд болж буурсан.

Хүнсний үнийн инфляци өнгөрсөн онд 30 гаруй хувьтай байсан бол 2013 оны 3-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.5 хувь болж саарсан. Хүнсний үнийн инфляци² 2012 оны эцэст 32.5 хувьд хүрч, үнийн нийт өсөлтийн гуравны нэгийг бүрдүүлэн, өнгөрсөн оны инфляцийн ерөнхий үзүүлэлтийг дээш хөтөлсөн гол хүчин зүйл байсан (График 6). Өнгөрсөн онд махны нийлүүлэлт хомсдож, махны үнэ өссөний улмаас хүнсний инфляци огцом хөөрөгдсөн. Ноос, ноолуурын урамшуулал, иргэн бүрт бэлнээр олгосон хувь хишгийн ачаар малчдын гар дээр бэлэн мөнгө хангалттай байх болж, мал нядлаж мах болгож зарах хэрэгцээ сонирхол нь буурснаар, махны нийлүүлэлт хомсдосон. 2013 он гарсаар мах, махан бүтээгдэхүүний үнэ нэлээд буурч, үнийн өсөлт нэгдүгээр сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.8 хувьтай байсан бол гуравдугаар сард 10.1 хувьтай болсон. Өнгөрсөн оны 11-р сараас хэрэгжүүлж эхэлсэн Үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд махны нөөц бүрдүүлэлт нэмэгдсэн нь энэхүү бууралтанд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн. Гэхдээ мах, махан бүтээгдэхүүний үнэ 2012 оны сүүлээс хойш 2013 оны гуравдугаар

² ҮСХ-ноос гаргасан ХҮИ-ийн албан ёсны мэдээнд эрхим хүч, шатахууны үнийг хүнсний үнийн бүлэгт хамруулсан байгаа. Энэхүү эдийн засгийн тоймд ашигласан хүнсний үнийн бүлэгт мах, сүү, сүүн бүтээгдэхүүнийг оруулж тооцсон бөгөөд эрчим хүч, шатахуун дээр салангид судалгаа хийсэн болно.

сар дуустал хугацаанд 16 хувиар өссөн тул өмнөх оны мөн үетэй харьцуулсан инфляцийн буурах хандлагыг болгоомжтой хүлээж авах учиртай.

Эрчим хүч, түлш шатахууны үнийн инфляци 2013 оны эхний улиралд харьцангуй аядуу байв. 2012 онд эрчим хүч, шатахууны инфляци өмнөх оны мөн үетэй харьцуулахад тогтвортой буурч, нэгдүгээр сард 24.5 хувьтай байсан бол 12-р сард 5.3 хувь болсон. Засгийн газраас хэд хэдэн удаа интервенци хийсний ачаар шатахууны үнэ 2012 оны хоёр болон дөрөвдүгээр саруудад тус тус буурсан боловч ОХУ-аас импортлох шатахууны хилийн үнэ нэмэгдсэний улмаас шатахууны үнэ 2012 оны дөрөвдүгээр улирлын түвшинд эргэж очсон. 2013 он гарсаар эрчим хүч, шатахууны үнэ харьцангуй тогтвортой байж, гуравдугаар сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.8 хувийн өсөлттэй гарсан. Тээврийн шатахууны үнэ өнгөрсөн арван хоёрдугаар сарын түвшинд хэвээр байна.

Инфляци 2012 онд бага зэрэг саарах төлөвтэй байгаа хэдий ч төсвийн тэлэлт үргэлжилж, мөнгөний бодлого саяхнаас богино хугацааны зээлийн хүүг бууруулах замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих чиглэлтэй болсон тул дөнгөж 10 хувийг давсан түвшинд байхаар байна. Монголбанк мөнгөний бодлогын байр сууриа саяхнаас сулруулсны зэрэгцээ төсвийн орлогоос хол давсан зарлага санхүүжилт, төсвөөс гадуурх санхүүжилтээр дамжин төсвөөс эдийн засагт оруулах дэмжлэг үргэлжлэх учраас эрэлтийн талын дарамт нэмж хуримтлагдан, инфляцийг хөөрөгдөх хүчин зүйл байх төлөвтэй байна. Өнгөрсөн оны 10-р сараас хойш хэрэгжиж байгаа Үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд засгийн газраас хийж байгаа интервенцийн үр нөлөө аажмаар бий болж чадвал мах, шатахууны нийлүүлэлтийн талын дарамт зарим талаар арилж магадгүй. Гэхдээ уг хөтөлбөр ямар бодит үр нөлөөтэй байхыг он дуустал харах хэрэгтэй байна. Өнгөрсөн арваннэгдүгээр сараас 2013 оны 3-р сар хүртэлх хугацаанд шатахууны үнэ ганц удаа 12-р сард 6 хувиар өсч, үүнээс хойш өөрчлөгдөөгүй. Мах, махан бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн арваннэгдүгээр сараас хойш 16 хувиар өссөн. Үнийг тогтворжуулах хөтөлбөрийн тухайд хэд хэдэн асуудал санаа зовоож байгаа. Тухайбал, хөтөлбөрийн үр нөлөөтэй байдал, төв банк төсөвтэй адилтгах үйл ажиллагаанд оролцож байгаа явдал зэрэг болно. (Энэ талаар Шигтгээ 1-т дэлгэрэнгүй өгүүлэв.)

2013 он гарсаар инфляци нэлээд саарч, 3-р сард нэг оронтой тоонд орлоо.

График 5: Улаанбаатар хотын хэрэглээний үнэ (хувь, жилийн өөрчлөлт)



2012 онд инфляцийг хөөрөгдсөн гол хүчин зүйл нь махны үнийн өсөлт байсан бөгөөд 2013 оны нэгдүгээр улиралд өсөлт саарсан.

График 6: Хүнсний инфляцийн үндсэн хүчин зүйл (хувь, жилийн өөрчлөлт)



Эх сурвалж: УСХ, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоолол.

Шигтгээ 1: Үнийг тогтворжуулах хөтөлбөр

Монгол улсын Засгийн газар, Монголбанк “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцоллын санамж бичгийг 2012 оны 10-р сард байгуулсан. Үнийг тогтворжуулах хөтөлбөр нь дөрвөн дэд хөтөлбөрүүдээс бүрдэж байна. Үүнд: 1) хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах; 2) шатахууны жижиглэн худалдааны үнийг тогтворжуулах; 3) өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах; 4) барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах. Хөтөлбөрийн нийт өртөг 720 тэрбум төгрөг болох тооцоо бий. Хөтөлбөрийн үндсэн зорилго дээрх дөрвөн чиглэлд нийлүүлэлтийн талын саад бэрхшээлийг шийдвэрлэхэд оршиж байна. 2013 оны 2-р сарын байдлаар нийт 229.6 тэрбум төгрөгийн зээлийн шугамыг оролцогч банкуудаар дамжуулан дотоодын шатахуун импортлогчид, мах боловсруулах, гурил үйлдвэрлэх салбарт нээж ашиглуулаад байна.

- Түлш шатахууны үнийг тогтворжуулах арга хэмжээнүүд шатахууны жижиглэн худалдааны үнийг тогтворжуулахад чиглэсэн. 2012 оны 10-р сараас хойш 105.3 тэрбум төгрөгийн зээлийн шугамыг жилийн 3.8 хувийн хүүтэйгээр нээж, түлш шатахуун импортлогч 11 компаниудад ашиглуулсан. Эдгээр арга хэмжээний зорилго нь тааламжтай нөхцөлтэй санхүүжилтийг арилжааны банкуудаар дамжуулан шатахууны жижиглэн худалдааны үнийг бөөний үнийн өөрчлөлтөөс хамааралгүй болгоход оршиж байна. Үүний зэрэгцээ, Засгийн газар БНХАУ болон БНСУ-тай шатахуун импортлох тухай гэрээ хэлэлцээр байгуулж, түлш шатахууны импортын гарцыг шинээр бий болгосон. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 20 мянган тонн шатахуун импортлоод байна. Монгол улсын түлш шатахууны хэрэглээний 90 орчим хувийг одоогоор ОХУ-аас импортлон хангаж байна.
- Үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хоёр дахь бүрэлдэхүүн нь тээврийн саад бэрхшээлийг арилгах замаар өргөн хэрэглээний импортын бараа бүтээгдэхүүний өртгийг бууруулахад чиглэж байна. Энэ хүрээнд тусгай зориулалтын вагон ашиглах, төмөр замын үйлчилгээг сайжруулах, ачих буулгах хэсгийн ажлыг оновчтой зохион байгуулах, “хаалганаас хаалганд” үйлчилгээ нэвтрүүлэх, өндөр ачаалалтай, тэмдэглэлт баярын үеэр нэмэлт вагон гаргаж, төмөр замын тээврийг нэмж зохион байгуулах зэрэг арга хэмжээнүүд хэрэгжиж байна.
- Гурав дахь дэд хөтөлбөр нь мах, гурилын үнийг тогтворжуулахад чиглэж байна. ХҮИ-ийн нийт сагсны 20 орчим хувь, хүнсний ХҮИ-ийн сагсны 60 гаруй хувийг энэ хоёр бүтээгдэхүүн эзэлдэг. Энэ хүрээнд мах, гурилын нөөц бүрдүүлэлтийг сайжруулахад анхаарч ажиллан, 122 тэрбум төгрөгийн 3.8 хувийн хүүтэй зээлийг мах, гурилын үйлдвэрүүдэд олгосон. Барилга, орон сууцны салбарт чиглэсэн дэд хөтөлбөр 2013 оны 2-р сарын байдлаар хараахан хэрэгжиж эхлээгүй байна.

Үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хэрэгжилт эхний үе шатанд байгаа учраас бодит үр дүн он дуустал гарах хэдий ч хөтөлбөрийн зарим арга хэмжээнүүдийн хүрээнд нийлүүлэгчдэд нэмэлт зээл олгож, нөөцийн хэмжээ нэмэгдсэн нь шууд нөлөөлж, тодорхой бараа бүтээгдэхүүний үнийг бууруулах боломжтой байж болно. Гэхдээ дараах асуудлууд санаа зовоосон хэвээр байгаа тул эрх бүхий байгууллагууд эдгээрт анхаарлаа сайтар хандуулах хэрэгтэй байна. Үүнд:

- Хөтөлбөрийн хүрээнд төв банк мөн чанартаа засгийн газрын хэрэгжүүлэх учиртай нийлүүлэлтийн талын арга хэмжээнд шууд оролцож байна. Монголбанкнаас арилжааны банкуудад олгож буй зээлийг оны эхээр дотоодын зах дээр Засгийн газрын бонд гаргах замаар нөхөн санхүүжүүлэхээр төлөвлөсөн байсан. Төв банкны оролцоотойгоор хэрэгжиж буй энэхүү хөтөлбөрийн тухайд төв банк хэзээ хөтөлбөрийн хэрэгжилтээс гарахыг тодорхой зааж, хөтөлбөрийн өртгийг нэгдсэн төсөвт суулгаж өгөх шаардлагатай байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлснээр бүтцийн саад бэрхшээлийг шийдвэрлэхийг зорьж байгаа хэдий ч хөтөлбөрийн хүрээнд эдийн засагт суурь мөнгө шинээр орж байна. Бодлогын арга хэмжээний үр дүнд нийлүүлэлтийн хязгаарлалтууд багасаж, нийлүүлэлтийн тал дээр авч буй арга хэмжээнүүдийн үр нөлөө дунд болон урт хугацаанд харагдаж эхэлнэ. Иймд хөтөлбөрийн зорилтот үр өгөөж илүү урт хугацаанд гарах тул

хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй мөнгөний нийлүүлэлт инфляци дээрх эрэлтийн талын дарамтыг ойрын хугацаанд нэмж болзошгүй. Хөтөлбөрийн хугацаанд мөнгөний стерилизацийг зохих байдлаар хийхийн зэрэгцээ цаашид инфляцид үзүүлэх нөлөөллийг хатуу хянах нь зүйтэй.

- Хөтөлбөрийн хүрээнд түлш шатахууны бэлтгэн нийлүүлэгчдэд татаас олгох замаар шатахууны жижиглэн худалдааны үнийг тогтворжуулах зорилготой. Ингэснээр үнэ өссөн ч гэсэн түлш шатахууны хэт их эрэлт хуримтлагдана. Хөтөлбөр төлөвлөгөөний дагуу гурван жилийн хугацаанд хэрэгжиж дуусахад шатахууны хангагдаагүй эрэлт дахин үнийн дарамт учруулахаас гадна нийлүүлэлтий талын хүчин зүйлүүд хяналтаас гадуур байна. Хэрвээ гурван жилийн дараа засгийн газар шатахууны үнийг тогтвортой байлгах үүднээс хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд төсөв дээр томоохон дарамт үүсч болзошгүй юм.

Эх сурвалж: Дэлхийн Банкны мэргэжилтнүүд.

Нэгдсэн төсвийн үр дүнгийн гүйцэтгэл, төлөв байдал

Нэгдсэн төсвийн тэнцэл 2012 нэлээд доройтож, ДНБ-ий 8.4 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай гарсан нь сүүлийн 13 жилийн хугацаанд хамгийн өндөр үзүүлэлт болов (График 7). 2008-2009 оны санхүү эдийн засгийн хямралын үеэр хүртэл нэгдсэн төсвийн алдагдал ДНБ-ий дөнгөж 5 хувьтай тэнцэж байсан. Төсвийн тэнцэл өнгөрсөн онд ийнхүү их хэмжээгээр доройтсон нь орлогын төлөвлөгөөг хэт өндөр тооцож, зарлага санхүүжилтийг хэмжээгүй ихээр төлөвлөсөнтэй шууд холбоотой юм. 2012 оны төсөвт есдүгээр сард хоёр дахь тодотголыг хийхдээ орлогын төлөвлөгөөг багасгахыг оролдсон боловч 2012 оны гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн орлого, тусламжийн дүн төлөвлөгөөнөөс 12.1 хувиар тасарсан. Орлогын төлөвлөгөө ийнхүү ихээр тасарсныг эрдэс бүтээгдэхүүний зах зээл дээр урьдчилан тооцоолох боломжгүй савалгаа үүссэн, мөн Сангийн яамны орлогын төсөөлөл гаргах чадавхи сул хэвээр байгаатай зарим талаар холбож болно. Гэвч нэгдсэн төсвийн төслийг УИХ дээр хэлэлцэх үеэр нэмэлт зарлагыг санхүүжүүлэх зорилгоор эдийн засгийн хувьд үндэслэлгүй тооцоо судалгааг ашиглан орлогын тооцоог өсгөж тавих хандлага давамгайлдаг тул төсвийн орлого хэт өндөр төлөвлөгддөг. Ийнхүү хэт өөдрөг тооцоо судалгаан дээр үндэслэж төсвийн орлогын төлөвлөгөөг гаргадагаас орлого ихээр тасрах нөхцөл бүрддэг. Төсвийн төлөвлөгөөг үнэмшилтэй болгох үүднээс орлогын төлөвлөгөөнд ашигладаг суурь нөхцлийг бууруулж тооцон, илүү үндэслэлтэй, бодитой тооцоо гаргадаг болох хэрэгтэй байна.

Нийт орлого, тусламжийн дүн 2012 онд дөнгөж 10.8 хувиар өсч, 2011 оны 43 хувийн өсөлтөөс эрс багасаж, 26 хувийн өсөлтийн төлөвлөгөөгөөнөөс хол тасарсан (График 8). Бодит дүнгээр төсвийн орлого өмнөх онтой харьцуулахад 6.7 хувиар буурсан. Нүүрсний экспорт багассанаас эрдэсийн орлого эрс буурсан нь төсвийн орлогын өсөлт муу гарах үндсэн шалтгаан байлаа. Энэ нь төсвийн тогтвортой байдал маш их савалгаатай, урьдчилан тооцох боломжгүй эрдэсийн орлогоос улам ихээр хамаарах болсныг тод харуулж байна.

- **2012 оны сүүлийн хагаст нүүрсний гадаад эрэлт багасч, эрдэсийн нийт орлого³ өнгөрсөн онд 1.3 их наяд төгрөг байсан бол 35.6 хувиар буурч, 800 тэрбум төгрөг болсон.** Нийт экспортын 40 гаруй хувийг бүрдүүлдэг нүүрсний экспорт 2012 онд 15 хувиар унасан. Эрдэсийн экспорт буурсанаар төсөвт төвлөрөх эрдэсийн орлого ч багассан. Уул уурхайн салбарын ашгийн татварын орлого 50 хувь, нөөц ашигласны төлбөр 46.4 хувь, гаалийн татварын орлого 62.6 хувиар тус тус багассан. Ингэснээр 2011 онд 28.2 хувьтай байсан эрдэсийн орлогын төсвийн нийт орлогод эзлэх хувь хэмжээ 2012 онд 16.4 хувь болж буурсан (График 9).

³ Эрдэсийн орлогод нэгдсэн төсвийн үр дүнгийн тайланд тусганы дагуу уул уурхайн компанийн ашгийн татвар, нөөц ашигласны төлбөр, ногдол ашиг, гаалийн татварыг оруулж тооцсон.

- **Эрдэсийн бус орлого 2012 онд 29.1 хувиар буюу эрдэсийн бус ДНБ-ий өсөлтийн түвшинд өссөн.** Нэрлэсэн орлого, хэрэглээ нэмэгдэхийн хирээр хувь хүний орлогын татварын орлого 49 хувиар, дотоодын хэрэглээний НӨАТ 35 хувиар тус тус нэмэгдсэн. Гэхдээ ОТ төслийн бүтээн байгуулалтын эхний үе шат хэрэгжиж дуусах дөхсөн тул импортын барааны (голдуу уул уурхайн тоног төхөөрөмж) НӨАТ-ын орлогын өсөлт 5.6 хувь болж буурсан.

Нэгдсэн төсвийн урсгал зарлага ихээр нэмэгдсэн тул нийт зарлага 2012 онд 22 хувиар өсч, орлогын өсөлтийг хол давав. Төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2009 онд 35 хувь байсан бол 2012 42.5 хувьд хүрч огцом дээшилсэн. Төсвийн зарлага ихээр нэмэгдсэний үндсэн шалтгаан нь урсгал зарлага 37.6 хувиар үлэмж өссөн хэрэг байв. Харин урсгал зарлага нэмэгдсэн нь төрийн албан хаагчдын цалин урамшуулал 49.2 хувь, бэлэн мөнгөний шилжүүлэг 16.8 хувиар тус тус өссөнтэй шууд холбоотой. Хүүгийн төлбөр 2012 онд гурав гаруй дахин нэмэгдэж, 126 тэрбум төгрөгт хүрсэн. Засгийн газрын дотоодын бондын хүүгийн төлбөр нийт хүүгийн төлбөрийн 62 хувь (78.7 тэрбум төгрөг)-ийг эзэлж байсан бол Хөгжлийн банкны бондын хүүгийн зардал 2012 онд 24.3 тэрбум төгрөг байв.

Урсгал зарлагын санхүүжилт огцом нэмэгдсэн боловч хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл нэлээд дутуу хийгдэж, тасарсан орлогын ихэнх хэсгийг шингээж авснаас гадна улсын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гүйцэтгэх хүчин чадал хязгаарлагдмал байгааг харуулж байна. Хөрөнгө оруулалтын зардал 2012 оны гүйцэтгэлээр дөнгөж найман хувиар өсч, төлөвлөгөөнөөс 20 хувиар дутуу гүйцэтгэгдсэн (График 11). Улсын хөрөнгө оруулалтын зардал нь мөн чанартаа үзэмжээр хэрэгждэг бөгөөд өнгөрсөн онд их хэмжээгээр дутуу гүйцэтгэгдсэн нь төсвийн орлого тасрах үед оны дундуур тодотгол хийх шаардлага улам их үүсдэг болох нөхцөл бүрдсэнийг илтгэж байна. Орлогын төлөвлөгөө тасарсан хэдий ч урсгал зарлагын санхүүжилт төлөвлөгөөний дагуу хийгдсэн. Харин хөрөнгө оруулалтын зардал төсвийн зарлагыг бууруулах шаардлагын ихэнх хэсгийг өөртөө шингээж, хамгийн хүндийг үүрсэн. Мөн түүнчлэн, өнгөрсөн гурван жилийн хугацаанд улсын хөрөнгө оруулалтын зардал үлэмж нэмэгдэж⁴, эрх бүхий байгууллагын хөрөнгө оруулалтын шахуу төсөл, арга хэмжээг зохих ёсоор удирдан гүйцэтгэх хүчин чадал хязгаарлагдмал болж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үр дүнтэй гүйцэтгэх боломж багасаж байна. Их засвар, үйлчилгээнд илүү их хөрөнгө хуваарилах эрэлт өндөр байгаа хэдий ч 2012 онд санхүүжилтийн эх үүсвэр дутагдалтай байснаас их засвар, үйлчилгээний зарлага 5.7 хувиар багассан.

2013 онд төсвийн төлөв байдал дээрх байдалтай төстэй байхаар байна; батлагдсан төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд заасан ДНБ-ий 2 хувийн хязгаарт багтсан хэдий ч гүйцэтгэлээр 7 хувиас давах төлөвтэй байна. Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө хэт өөдрөг хэвээр байгаа бөгөөд орлогын гол эх үүсвэрүүд дээр үндэслэлгүй тооцоолол хийсэн байгаа. 2013 оны батлагдсан төсвийн орлогын төлөвлөгөөг гаргахдаа 2012 оны хэт өндрөөр тооцсон орлогыг суурь болгосон. 2012 оны орлогын төлөвлөгөө гүйцэтгэлээр 12 хувиар тасарсан. Орлогын төлөвлөгөөнд импортын НӨАТ орлого 47 хувь, гаалийн татварын орлого 76 гаруй хувиар тус тус нэмэгдэхээр тооцсон нь 2012 оны гүйцэтгэлтэй (5.6 хувь болон 6.3 хувь) харьцуулбал үлэмж өсөлт юм. Мөн түүнчлэн ОТ төслийн хөрөнгө оруулагчидтай хийсэн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар одоо хийгдэж байгаа гэрээ хэлэлцээрийн үр дүнд төсөвт 445 тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэр төвлөрөх учиртай байгаа. Гэхдээ гэрээ хэлэлцээр ямар үр дүнд хүрэх нь тодорхойгүй байна. Энэ бүгд нөхцөл байдлаас шалтгаалан нэгдсэн төсвийн орлого батлагдсан дүнгээс 15-20 хувиар тасрах магадлалтай байна. Дэлхийн Банк төсөөлөл хийхдээ төсвийн орлого энэ хэмжээгээр тасарч, улмаар зарлага санхүүжилт төлөвлөгөөнөөс 5 хувиар дутуу хийгдэнэ гэж үзсэн. Энэ тохиолдолд нэгдсэн төсвийн алдагдал 2013 онд ДНБ-ий 6 хувьд хүрч, тэнцвэржүүлсэн алдагдал 7 хувиас давахаар байна.

⁴ Хөрөнгө оруулалтын зардал 2012 онд 2009 оны түвшингээс 2.5 дахин өссөн.


Төсвийн төлөв байдал хэврэг байхын хажуугаар Үнийг тогтворжуулах хөтөлбөр болон Хөгжлийн банк хэмээх төсвийн гадуурх хоёр эх үүсвэрээс нийгмийн чанартай төслүүдэд санхүүжилт хийгдэх болно. Мөн Чингис бондын хөрөнгийг зарцуулна. Эдгээр эх үүсвэрийг төсөвт тусгаж харуулбал төсвийн нийт алдагдал 2013 онд ДНБ-ий 7 хувьтай тэнцэх хэмжээгээр нэмэгдэж, 2013 онд 13 орчим хувьд хүрэх болно. Хөгжлийн банкнаас төсвийн гадуур хийсэн санхүүжилтийг 2012 оны төсвийн гүйцэтгэлд оруулж тооцвол нэгдсэн төсвийн нийт тэнцэл 2012 онд ДНБ-ий 10.4хувьд хүрэх байлаа.

- Үнийг тогтворжуулах хөтөлбөр — Монголбанкнаас одоогоор түр санхүүжүүлж байгаа бөгөөд мөн чанартаа төсвийн бодлогын арга хэмжээ тул үүнийг аль болох ойрын үед төсвийн төлөвлөгөөнд тусгаж харуулах хэрэгтэй. Хөтөлбөрийн нийт өртөг 720 тэрбум төгрөг буюу 2013 оны ДНБ-ий 4 гаруй хувьтай тэнцэхээр байна. 2013 оны 2-р сарын байдлаар 230 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гаргаад байна.
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд тогтоосон төсвийн тусгай шаардлаганд хамаарахгүй байгаа Хөгжлийн банк хэмээх 100% төрийн өмчит аж ахуй нэгж нь хөгжлийн төслийг улсаас санхүүжүүлэх гол хэрэгсэл болоод байна. Хөгжлийн банкны эх үүсвэрийг Засгийн газрын илэрхий баталгаатайгаар бүрдүүлсний дотор 2012 онд 580 сая ам. долларыг олон улсын захаас босгосон. Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төслүүдийн ихэнх нь нийгмийн чанартай буюу эдийн засгийн үр ашиггүй байсан нь цаашид төсвөөс төлөх хариуцлага үүсч болзошгүй, макроэдийн засгийн тогтвортой байдалд ямар нөлөө үзүүлэх бол гэсэн болгоомжлол төрүүлж байна. 2012 онд Хөгжлийн банкнаас олгосон зээлийн бараг тал хувийг буюу 488.2 тэрбум төгрөгийг орон нутгийн автозам, орон сууцны зээл гэх мэт нийгмийн чанартай төслүүдэд зарцуулж, дөрвөн жилийн дараа эргэн төлөлтийг улсын төсвөөс гаргахаас өөр аргагүй байдал үүснэ.
- Чингис бондын хөрөнгийг ашиглан хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Бондын хөрөнгийн дөрөвний нэгийг зарцуулахад л ДНБ-ий гурав гаруй хувьтай тэнцэх хэмжээний төсвийн нэмэлт зарлага гарах болно. Үүний зэрэгцээ, төслийн нийт өртгийн зөвхөн гуравны нэгийг засгийн газар хариуцахаар хязгаарлалт тогтоож, хувийн хэвшлийн нэмэлт санхүүжилтийг оруулах тул улсын хөрөнгө оруулалтын төслүүдийн макроэдийн засгийн үр нөлөө үржүүлэгдэх боломжтой юм. Засгийн газар их хэмжээний зээлийг гадаадаас хөнгөлөлттэй бус нөхцөлөөр авахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зохицуулалтанд хамаарах төсвийн тэнцэлд ямар нөлөөлөл үзүүлэх, эсвэл гадаадаас босгосон санхүүжилтийг хэрхэн ашиглах талаар тодорхой төлөвлөгөөгүй байсан нь санаа зовоож байна. Бондын хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтын төслүүдийг төлөвлөх, техник эдийн засгийн үндэслэлийг тооцох зэрэгт цаг хугацаатай шаардлагатай. Нэн ялангуяа, засгийн газрын шууд зээллэгийн үр дүнд бондын эх үүсвэрийг босгосон бөгөөд бондын хөрөнгийн зарцуулалтыг төсвөөс гадуур бус төсвийн бүрэлдэхүүн болгож тусгах нь зүйтэй.

2013 оны эхний улиралд төсвийн гүйцэтгэл гамтай явагдаж, төсөв ашигтай гарсан. Нэгдсэн төсвийн нийт орлого нэгдүгээр сараас гуравдугаар сарын хооронд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.8 хувиар өссөн. Батлагдсан төсвийн орлогын жилийн төлөвлөгөө 47 хувиар өсөх ёстойг харгалзан үзвэл орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл даруухан байсан нь он дуустал төсвийн орлого ихээхэн тасрах магадлалыг баталгаажуулж байна. Импортын өсөлт зогсож, импортын НӨАТ, гаалийн татварын орлого хураалт эхний улиралд 15.7 хувь, 16.5 хувиар тус тус буурч, сул байснаас орлогын өсөлт зогсонги болсон. Орлого бүрдүүлэлт тааруу байсан тул зарлага санхүүжилт дутуу хийгдсэн; нийт зарлага өнгөрсөн оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлтэй харьцуулахад 7.7 хувиар буурсан. Төсөвт тодотгол хийж, төсвийн алдагдалыг багасгах зохих төлөвлөгөөг албажуулж, он дуустгал зарлага санхүүжилт огцом нэмэгдэхээс сэргийлж, орлогын бодит төлөв байдлыг тусгах нь зүйтэй.

Нэгдсэн төсвийн нийт алдагдал 2012 онд ДНБ-ий 7 хувьд хүрч, сүүлийн 13 жилд байгаагүй өндөр түвшинд очив.

График 7: Нэгдсэн төсвийн тэнцлийн чиг хандлага (ДНБ-д эзлэх хувь)




Төсвийн бодлого хямралын өмнөх үеийнх шиг мөчлөг дагасан шинжтэй болж ирлээ.

График 8: Төсвийн орлого, зарлагын чиг хандлага (12 сарын гулсмал нийлбэр, ДНБ-д эзлэх хувь)




Эрдэсийн орлого 2012 онд үлэмж буурсан бол эрдэсийн бус орлогын гүйцэтгэл өндөр байлаа.

График 9: Эрдэс баялгийн орлогын чиг хандлага (ДНБ-д эзлэх хувь)




Нийт орлого 2012 онд төлөвлөгөөнөөс 12 хувиар тасарсан байхад 2013 оны орлогын төлөвлөгөө бас л өөдрөг байна.

График 10: 2012 оны гүйцэтгэл, 2013 оны төлөвлөгөөний харьцуулалт (хувь)




Орлогын үндэслэлгүй тооцоон дээр суурилан хөрөнгө оруулалтын зарлага 80 хувиар өсөх гэж байна.

График 11: Зарлагын өөрчлөлт (хувиар): 2012 он ба 2013 он



Нэгдсэн төсвийн үр дүнгийн төлөв 2013 онд нэг их сайжрахгүй.

График 12: Нэгдсэн төсвийн алдагдалын тооцоо (ДНБ-д эзлэх хувь)



Шигтгээ 2. Монгол улсын Өрийн удирдлагын стратеги

Монгол улс олон жилийн турш гадаадын хөнгөлөлттэй зээлийг авч ашиглаж ирсэн. Хөнгөлөлттэй зээл нь бага хүүтэй, маш урт хугацаатай байдаг тул зээлийн хүү, валютын ханшийн өөрчлөлтийн нөлөөлөл бага байдаг. Эдийн засаг хөгжиж, ийм төрлийн зээлийг авч ашиглах боломж аажмаар үгүй болж, зээллэгийг зах зээлийн нөхцөлөөр авах тохиолдол ихсэж байна. Энэ нь өндөр өртөг, эрсдэлтэй гэсэн үг боловч өрийн удирдлагын үүднээс авч үзвэл засгийн газар санхүүгийн нөхцөлөө өөрөө сонгох тул үүрэх эрсдэлийн түвшингээ өөрөө тогтооно гэсэн үг юм.

Дунд хугацааны өрийн удирдлагын стратеги гэдэг нь засгийн газрын өрийн зорилтот бүтэцэд хүрэхийн тулд засгийн газраас хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээ бөгөөд засгийн газар өртөг, эрсдэлийн хувьд ямар байр суурьтай байгааг харуулж байдаг. Тухайн улсын эрх бүхий байгууллагын өрийн удирдлагын зорилтыг үүгээр дамжуулан хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, засгийн газрын санхүүжилтийн эрэлт хэрэгцээ, төлбөрийн үүрэг хариуцлагыг эрсдэлийн зохистой түвшинтэй уялдуулан, байж болох хамгийн бага өртгөөр хангах явдал юм. Өрийн удирдлагын стратеги нь өрийн хэмжээнээс илүүтэйгээр өрийн багцын эрсдэлийн түвшинг, тодруулбал, өрийн үйлчилгээний өртөгт гарч болох өөрчлөлт, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг удирдахад түлхүү анхаардаг. Өрийн бүтэц нь эрсдэлийн түвшинг тодорхойлно, өөрөөр хэлбэл, дотоод гадаадын зах зээл дээр гарсан өөрчлөлтийг дагаад хүүгийн түвшин эсвэл төгрөгийн ханш савласнаас төсвийн зардал, өрийн хэмжээ яаж өөрчлөгдөхийг харуулдаг. Өрийн удирдлагын анхаарлын төвд өрийн бүтэц байдаг хэдий ч өрийн хэмжээг тодорхойлогч гол хүчин зүйл нь төсвийн бодлого юм.

Монгол улсын Засгийн газар өнгөрсөн арван жилийн хугацаанд өрийн удирдлагын чиглэлээр томоохон ахиц дэвшил гаргасан. 2012 онд Сангийн яам 2012-2014 онуудад баримтлах өрийн удирдлагын стратеги боловсруулж гаргасан. Саяхнаас дотоодын өр нэмэгдсэн нь засгийн газрын үнэт цаасны зах зээлийг хөгжүүлж, гадаад валютын ханшийн нөлөөллийг багасгах утгаараа нааштай үйл явдал мөн. Мөн түүнчлэн, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд өр, төсвийн алдагдал дээр дээд хязгаарыг тогтоож өгсөнөөр өрийн бүтэц, хэмжээг тодорхойлох тул өрийн удирдлагын стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэг болсон.

2012 оны сүүлээр олон улсын санхүүгийн зах дээр бонд арилжсан нь гадаадаас зээллэг авах бодлого, өрийн удирдлагын ерөнхий стратегийн уялдаа холбоог сайжруулах шаардлагатайг харуулж байна. Зээллэг авах үйл ажиллагааг Эдийн засгийн хөгжлийн яам удирдаж явуулсан бололтой. Гэтэл тус яам Дунд хугацааны өрийн удирдлагын 2012-2014 онуудын стратегид тодорхой хамаарал байхгүй байна.

Зах зээлийн үүднээс авч үзвэл бондыг амжилттай гаргаж чадсан хэдий ч хэмжээ, бүтэц нь өрийн өртөг, эрсдэлийн хүрээг үлэмж өөрчилсөн. Жишээлбэл, бонд гаргаснаар гадаад өрийн хувь хэмжээ нэмэгдсэн атал өрийн удирдлагын стратегид заасан зорилт нь гадаад өрийн хувь хэмжээг бууруулж, дотоод зээллэгт түлхүү анхаарч, засгийн газрын үнэт цаасны дотоодын зах зээлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршиж байв. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үүднээс авч үзвэл өрийн хэмжээг нэмэгдсэнээр өрийн түвшинг хуулинд заасан хязгаарт багтаах нь төвөгтэй асуудал болж магадгүй. Өрийн удирдлагын үүднээс авч үзвэл хамгийн чухал нь өрийн эрсдэлийн түвшин гэдэг бол дотоодын мөнгөн тэмдэгтийн ханш багахан хэмжээгээр суларсан ч төсөв дээр зохих арга хэмжээ аваад ч өрийн хязгаарыг зөрчихөд хүргэж болзошгүй байдал юм.

Цаашид өртэй холбоотой бүхий л шийдвэрийг олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн хүлээн зөвшөөрч, хэвлэгдсэн байгаа дунд хугацааны өрийн удирдлагын стратегийн хүрээнд гаргах хэрэгтэй. Уялдаа холбоог тууштай хангах хамгийн үр дүнтэй арга бол засгийн газарт өрийн удирдлагын стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг бүхий нэгж ажиллуулах явдал юм. Ийм нэгж ихэнхдээ Сангийн яамны бүтэц дэхь газар байдаг. Хоёр дахь шилдэг хувилбар нь Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Монголбанкны төлөөлөл бүхий өрийн удирдлагын дээд түвшний хороо байгуулах явдал юм. Энэхүү хороо зээллэгийн бүхий л шийдвэрүүдийг хэлэлцэж батлах бөгөөд дунд хугацааны өрийн удирдлагын стратегийн хэрэгжилтийн талаар жил бүр танилцуулж болно.

Гадаад салбар

Төсвийн зарлага санхүүжилт оргилж, дотоод эрэлт нэмэгдэж байгаа энэ үед гадаад салбарын тэнцвэргүй байдал 2012 онд онд түүхэндээ байгаагүй өндөр түвшинд хүрч, урсгал дансны алдагдал 3.2 тэрбум ам. доллар болж, ДНБ-ий 31.3 хувьтай тэнцэв (График 13). Гадаад худалдааны алдагдал түүхэндээ байгаагүй өндөр түвшинд хүрч, урсгал дансны тэнцвэр алдагдахад хүргэсэн. Экспорт нэг жилийн дотор 9 хувиар буурч, импорт 2.1 хувиар өссөнөөс гадаад худалдааны алдагдал 2.4 тэрбум ам. доллар

хүрсэн. Аялал жуулчлал, тээврийн үйлчилгээ хумигдсаны улмаас үйлчилгээний тэнцэл 1.2 тэрбум ам. долларын алдагдалтай гарсан.

Эрдэс бүтээгдэхүүний экспортын гол бүтээгдэхүүнүүд болох нүүрс, зэсийн экспорт огцом буурснаас нийт экспорт 9 хувиар буурч, гадаад худалдааны алдагдал 2012 онд маш ихээр өссөн (График 14). Нүүрсний экспортын хэмжээ 1.8 хувь, нэг тонн нүүрсний үнэ 14.7 хувиар тус тус багассанаас нүүрсний экспорт 2012 оны 12-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.3 хувиар буурсан. Эрдэсийн гол бүтээгдэхүүний экспорт үлэмж хэмжээгээр буурсан нь БНХАУ-ын эрэлт, нэн ялангуяа өнгөрсөн оны сүүлийн хагаст суларсантай шууд холбоотой. Нүүрс, зэсийн экспортын үр дүн тааруу байсан хэдий ч хоёр талбайн олборлолт тогтвортой явагдсаны үр дүнд түүхий газрын тосны экспорт 33 хувиар нэмэгдэж, нийт экспортын 7.7 хувийг бүрдүүлэв. Алтны экспорт өмнөх оноос 8.4 хувиар өсч, зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн гэнэтийн ашгийн татварыг 2012 оноос хүчингүй болгосон нь зарим талаар нэмэр болсон. Махан бүтээгдэхүүний экспорт бага байснаас эрдэсийн бус экспорт 2012 онд 8.4 хувиар буурлаа.

Нийт импортын өсөлт 2012 онд 2.1 хувь болж саарсан нь өмнөх онд хоёр дахин өсч байсантай харьцуулахад үлэмж уналт юм. ОТ төслийн бүтээн байгуулалтын ажлын ихэнх хэсэг хийгдэж, уул уурхайн хүнд машин механизмын импорт зогсонги байдалд орсноос импортын өсөлт үндсэндээ саарсан. Машин механизм, тоног төхөөрөмжийн импортын өсөлт өмнөх онтой харьцуулахад сөрөг утгатай болсон бол тээврийн хэрэгслийн импорт мөн 15.9 хувиар буурсан. Энэ хоёр төрлийн импорт 2012 онд нийт импортын 43 хувийг эзэлжээ.

2013 оны эхний гурван сарын байдлаар гадаад худалдааны алдагдал их өндөр үзүүлэлттэй байв. Импортын бууралтын хурдац экспортынхоос түрүүлж байсан учраас гадаад худалдааны алдагдалыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад багасч байгаа. Нэгдүгээр сараас гуравдугаар сарын хооронд нийт экспорт 7.8 хувиар буурсан бол нийт импорт 17.3 хувиар саарчээ.


- **Зэс болон бусад бүтээгдэхүүний экспорт сэргэх тэмдэг бага зэрэг ажиглагдаж байгаа боловч нүүрсний экспорт бага байгаа тул нийт экспортын өсөлт сөрөг утгатай хэвээр байна.** Нийт экспорт 2012 онд унасны үндсэн шалтгаан нь нүүрсний экспорт байсан бөгөөд одоогоор тааруухан хэвээр байна. 2013 оны эхний гурван сард нүүрсний экспортын үнийн дүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43 хувиар буурчээ (График 15). Харин зэсийн экспорт он гарсаар бага зэрэг өсөлттэй байж, өмнөх оны нэгдүгээр улиралтай харьцуулахад 5.4 хувиар нэмэгдсэн байна. Засгийн газраас үзүүлж буй дэмжлэг нэмэгдэж, эрдэсийн бус экспорт, ялангуяа арьсан болон ноосон эдлэлийн экспорт оны эхнээс нэлээд эрчимтэй өсч, эхний гурван сарын байдлаар хоёр дахин гаруй нэмэгдээд байна.
- **Импортын өсөлт сөрөг утгатай болж, импортын уналтын хурдац 2013 он гарсаар нэмэгдэж байна.** Машин механизмын импорт нэгдүгээр сараас гуравдугаар сарын хооронд 17.8 хувиар, тээврийн хэрэгслийн импорт 41 орчим хувиар тус тус буураад байна (График 16). Хүнсний импортын өсөлт мөн саарч, эхний гурван сарын байдлаар 7.8 хувийн өсөлттэй гарсан. 2012 оны мөн үед хүнсний импортын өсөлт 33.6 хувь байсан юм. Импорт буурч байгаа нь ОТ төслийн нэгдүгээр үе шатны бүтээн байгуулалт дуусах дөхсөний суурь нөлөөлөл болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал багасахтай зэрэгцээд хувийн хэвшлийн бусад хөрөнгө оруулалт буурсантай холбоотой.

Гадаад худалдааны тэнцэл 2013 оны эхэнд сул хэвээр байх боловч оны сүүлийн хагаст сайжрах төлөвтэй байна. 2013 онд гадаад худалдааны төлөв байдал ОТ төслийн арилжааны зориулалттай олборлолтын төлөвлөгөөнөөс ихээхэн хамаарах учраас нэлээд тогтворгүй байна. ОТ төслийн арилжааны зориулалттай олборлолт төлөвлөсөн ёсоор энэ онд эхэлж чадвал зэс, алтны экспорт 2013 оны гуравдугаар улирлаас нэмэгдэх учиртай. Нүүрсний экспортын өсөлт БНХАУ-ын үйлдвэрлэлийн сэргэлтээс шууд

хамаарна. Гэхдээ он гарсаар нүүрсний экспорт ерөнхийдөө тааруу, БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт сүүлийн үед саарсан зэрэг нь нүүрсний экспортын цаашдын төлөв байдал муудах томоохон эрсдэл байгааг харуулж байна. ОТ төслийн бүтээн байгуулалт дуусч байгаатай холбоотойгоор машин механизм, тээврийн хэрэгслийн эрэлт багасах тул импорт 2013 оны эхний хагаст сул хэвээр байна. Харин улсын хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийг Чингис бондын хөрөнгөөр хэрэгжүүлж эхэлбэл импортын бууралт оны сүүлийн хагаст тодорхой хэмжээгээр нөхөгдөх болно. Гэхдээ хэдий хэмжээний хөрөнгө зарцуулагдах нь одоогоор тодорхойгүй хэвээр байна.

Урсгал дансны алдагдал 2012 онд түүхэндээ байгаагүй өндөр хэмжээнд хүрсэн.

График 13: Урсгал дансны тэнцэл (12 сарын гулсмал нийлбэр, сая ам. доллар)




Экспорт буурч, гадаад худалдааны алдагдал багасахгүй байна.

График 14: Экспорт, импорт (12 сарын гулсмал нийлбэр, сая ам. доллар)



Нүүрсний экспорт бага байгаагаас нийт экспорт буурч байна.

График 15: Нийт экспортын сарын өсөлт (хувь, жилийн өөрчлөлт, төрлөөр)



Импортын өсөлт 2013 он гарсаар сөрөг утгатай болов.

График 16: Нийт импортын сарын өсөлт (хувь, жилийн өөрчлөлт, төрлөөр)



Эх сурвалж: Монгол улсын эрх бүхий байгууллага, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоолол.

Шигтгээ 3: Эрдэс болон эрдэсийн бус бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээ

2012 онд эрдэсийн экспорт нийт экспортын 89 хувийг эзэлсэн. Хамгийн их экспортлогдсон бүтээгдэхүүнүүд гэвэл нүүрс (43.4 хувь) байсан бөгөөд түүний араас зэсийн баяжмал (19.1 хувь), түүхий газрын тос (7.7 хувь) болон алт (2.8 хувь) жагсав. Зэс, нүүрс, алт гэсэн гурван гол эрдэс бүтээгдэхүүнүүд нийлээд нийт экспортын орлогын 73 хувийг бүрдүүлжээ. Экспортыг улсаар авч үзвэл хамгийн их нь БНХАУ байсан бөгөөд Монгол улсын нийт экспортын 92.6 хувийг худалдан авчээ. Дараагийн том экспортлогч улс нь ОХУ (1.8 хувь) юм.

График 17: Экспортын бүтэц (2012 онд, нийт экспортод эзлэх хувь)





График 18: Импортын бүтэц (2012 онд, нийт импортод эзлэх хувь)



Экспортын бүтээгдэхүүний бүтэц өөрчлөгдөж ирсэн. Тухайлбал, 2007 онд нийт экспортын 43 хувийг зэс эзлэн тэргүүлж, дараагаар нь оёмол сүлжмэл бүтээгдэхүүн, алт байсан. 2012 оноос нүүрсний экспорт нэмэгдэж, зэсийн экспортын бүтээгдэхүүнүүд дунд эзлэх ач холбогдол нь огцом буурсан. Эрдэс бүтээгдэхүүний экспорт нэмэгдэхийн хирээр эрдэсийн бус салбарын нийт экспортод эзлэх хувь хэмжээ уул уурхайн өндөр өсөлт эхэлсэн 2006 оноос хойш эрчимтэй багассан. Эрдэсийн бус салбар 2005 онд нийт экспортын 57.5 хувийг эзлэж байсан бол 2007 онд 33.2 хувь болж буурчээ. 2012 онд энэ үзүүлэлт дөнгөж 10.8 хувьтай байв.

Хүснэгт 1: Уул уурхайн бус салбарын нийт экспортод эзлэх хувь

	2007	2008	2009	2010	2011	2012
Эрдэс бүтээгдэхүүн	66.8	67.9	66.4	81	89.2	89.2
Зэс	43.0	32.9	26.4	26.6	20.0	19.1
Алт	12.4	23.6	17.7	6.2	2.3	2.8
Нүүрс	6.2	7.3	16.0	30.3	46.7	43.4
Түүхий газрын тос	2.8	4.0	6.0	5.3	5.2	7.7
Эрдэсийн бус бүтээгдэхүүн	33.2	39.7	33.6	19	10.8	10.8
Оёмол, нэхмэл эдлэл	13.5	8.9	10.2	7.4	5	5.3
Байгалийн чулуу	12.1	23.7	16.4	6.1	2.3	2.8
Арьс шир	2.1	1.6	1.5	1.1	1.1	0.7

Эх сурвалж: Монгол улсын эрх бүхий байгууллага, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоолол.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал огцом буурч байгаа нь эдийн засгийн өсөлтийг доош нь чангаах нэг хүчин зүйл болж ирлээ. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал 2011 онд 4.6 тэрбум ам. долларын үзүүлэлттэй байсан бол 2012 онд 17 хувиар буурч, 3.8 тэрбум ам. доллар болсон. 2013 онд бууралт эрчимжсээр байна; гадаадын шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал нэгдүгээр сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41 хувь, хоёрдугаар сард 74 хувиар тус тус буурчээ. 2013 оны эхний хоёр сарын байдлаар гадаадын хөрөнгө оруулалт орох урсгалын хэмжээ өмнөх оны мөн үеийн хэмжээний дөнгөж 42 хувьтай тэнцэж байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт ийнхүү огцом буурах нь Монгол улсын эдийн засгийн төлөв байдалд чухал нөлөөтэй юм. Бүрэн төлөвшсөн хөрөнгийн зах бүрдээгүй, олон улсын санхүүгийн захаас хөрөнгө босгох боломж хязгаарлагдмал энэ нөхцөлд гадаадын хөрөнгө оруулалт нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн чухал суваг бөгөөд сүүлийн хоёр жилийн эдийн засгийн өсөлтийн гол тулгуур нь байв.


Гадаадын хөрөнгө оруулалт огцом буурсан нь 2012 онд нийт гадаадын хөрөнгө оруулалтын 70 гаруй хувийг бүрдүүлж байсан ОТ төслийн бүтээн байгуулалтын зардал хумигдаж байгаагийн илрэл юм. Гэхдээ бас гадаадын хөрөнгө оруулагчид Монгол улсын хөрөнгө оруулалтын орчны талаар хаширлаж байгаагийн дохио байж болох юм. 2012 оноос хойш Монгол улсын хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдал, урьдчилан мэдэх боломжийн талаар эргэлзээ улам бүр нэмэгдсэн. ОТ хөрөнгө оруулалтын гэрээний хувьд үргэлжилсэн санал зөрөлдөөн, мөн гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах хоёр хуулийн хүрээнд асуудал эргэлдэж байна. Энэ хоёр хууль нь Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулах тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулийн шинэ төсөл юм. Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулах тухай хууль 2012 оны 5-р сард батлагдсан бөгөөд уул уурхай, санхүү, болон хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо гэсэн стратегийн салбаруудын хувьд гадаадын хөрөнгө оруулагч нийт хувьцааны 49-өөс дээш хувийг эзэмшиж, оруулж байгаа хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 тэрбум төгрөгөөс давсан тохиолдолд Засгийн газрын танилцуулгыг үндэслэл УИХ уг хөрөнгө оруулалтыг зөвшөөрөх эсэх шийдвэр гаргана⁵. Ашигт малтмалын тухай хуулийн төсөл мөн хөрөнгө оруулагч нарын хувьд томоохон хүлээлтийг агуулж байсан. Хуулийн төслийн танилцуулгыг 2013 оны 1-р сард нийтэд анх хийсэн. Санал солилцсоны үндсэн дээр иргэний нийгэм, уул уурхайн салбар, бодлого боловсруулагчид илүү сайн зөвшилцөлд хүрэхэд хуулийн төсөл дээр нэмж ажиллах шаардлагатай нь тодорхой болсон. Энэ хоёр хуулийн баримт бичиг нь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмж татахад саад бэрхшээл болж магадгүй байсан учраас бизнесийн салбарынхан анхаарлаа хандуулсан. Гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах хандлагатай байсан тул Засгийн газраас Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулах тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, УИХ уг нэмэлт өөрчлөлтийг 2013 оны 4-р сарын 19-нд баталсан. Ингэснээр зөвхөн гадаадын төрийн өмчит хөрөнгө оруулагчид нийт хувьцааны 49-өөс дээш хувийг авч байгаа тохиолдолд УИХ-аас зөвшөөрөл авахаар болов.

Монгол улс олон улсын санхүүгийн зах дээр 1.5 тэрбум ам. долларын Чингис бондыг арилжаалж, хөрөнгө босгосон нь хөрөнгийн болон санхүүгийн данс үлэмж хэмжээний ашигтай гарахад нөлөөлөв. 2012 оны 12-р сард Монгол Улсын Засгийн газар 500 сая ам. долларын таван жилийн хугацаатай бондыг 4.125 хувийн хүүтэйгээр, 1 тэрбум ам. долларын 10 жилийн хугацаатай бондыг 5.125 хувийн хүүтэйгээр арилжаалсан. Бондын хөрөнгийг зарцуулах төлөвлөгөө тодорхой болтол одоогоор Монголбанкн дээр байршуулсан байгаа. Бондын эх үүсвэрийн ачаар гадаад валютын цэвэр албан нөөц 2013 оны 2-р сард 3.5 тэрбум ам. долларт хүрч, эрс нэмэгдсэн. Гэхдээ бондын эх үүсвэрийг хасч тооцвол гадаад валютын цэвэр албан нөөц 2 тэрбум ам. доллар болж багассан байгаа нь 2011 оны эцэст байсан хэмжээнээс 10 хувь буурсан хэрэг юм (График 20).

⁵ Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн хийсэн Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулах тухай хуулийн албан бус орчуулга.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2013 он гарсаар үлэмж буурч, эдийн засгийн байдлыг доройтуулах эрсдэл боллоо.

График 19: Гадаадын шууд хөрөнгө оруулалтын сарын цэвэр орох урсгал (сая а. доллар)



2012 оны сүүлээр олон улсын санхүүгийн зах дээр засгийн газрын бонд арилжсаны үр дүнд гадаад валютын цэвэр нөөц ихээхэн нэмэгдсэн.

График 20: Гадаад валютын цэвэр нөөц (тэрбум ам. доллар, хувь)



Эх сурвалж: Монгол улсын эрх бүхий байгууллага, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоолол.

Мөнгө, банкны салбар

Мөнгөний нийлүүлэлт, дотоодын зээлийн өсөлт саарсаар ирсэн нь Монголбанк өсөн нэмэгдэж байгаа инфляцийг хумихад сүүлийн хоёр жилийн хугацаанд анхаарч ирсний илрэл байв. Нийт мөнгөний дундаж өсөлт 2011 онд өмнөх онтой харьцуулахад 57.2 хувийн үзүүлэлттэй байсан бол 2012 онд 23.9 хувь болж буурсан бөгөөд 2013 оны эхний хоёр сард 17 хувь болж улам саарсан (График 21). Нөөц мөнгөний өсөлт энэ хугацаанд 66 хувиас 60 хувь болж бага зэрэг л саарсан. Нийт мөнгөний өсөлт, нөөц мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн зөрүү ихсэж байгаа нь 2012 онд эдийн засгийн өсөлт саарч, гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал буурахтай зэрэгцээд мөнгөний эргэц удааширч байгааг харуулж байна. Дотоодын зээлийн өсөлт саарч, илүү тогтвортой хурдацтай боллоо. Банкны нийт зээлийн өсөлт өнгөрсөн оны эхээр 60 гаруй хувьтай байсан бол оны эцэст 24 хувь, 2013 оны 2-р сард 26 хувь болж аажмаар саарав. Дотоодын зээлийн өсөлт буурсан нь өнгөрсөн оны туршид баримталсан мөнгөний хатуу бодлого, арилжааны банкууд чөлөөт эх үүсвэр дутагдалтай байсантай шууд холбоотой.

Банкны зээлийн уул уурхай, түүнтэй холбоотой салбаруудын төвлөрөл нэмэгдэж байна. Банкны нийт зээлийн багцанд уул уурхайн салбарын зээлийн эзлэх хувь хэмжээ 2011 оны эцэст 12.0 хувьтай байсан бол 2012 оны эцэст 14.3 хувьд хүрсэн байсан. Үл хөдлөх хөрөнгийн зээлийн хувь хэмжээ 14.1 хувиас 17.3 хувь, барилгын салбарынх 11.8 хувиас 16.1 хувь болж тус тус өссөн. Энэ гурван салбарт олгосон зээлийн хэмжээ нийлээд 2011 оны эцэст байсан нийт зээлийн багцын 37.9 хувийг эзлэж байсан бол 2012 оны эцэст 47.7 хувьд хүрчээ. Эдгээр салбаруудад олгох зээл нэмэгдэж байгаа нь эдгээр салбаруудын үйл ажиллагаа идэвхжиж байгаатай холбоотой хэдий ч эдгээр нь эрдэс бүтээгдэхүүний зах зээлийн тэлэлт, агшилтын мөчлөгийн нөлөөлөлд өртөмтгий учраас байнгын анхааралдаа байлгах нь зүйтэй.

Банкны хадгаламжийн өсөлт 2012 онд мөн саарсан боловч 2012 оны сүүлийн хагасаас 2013 оны эхэн үе хүртэл жигд хэмтэй өссөн. Банкны нийт хадгаламж 2011 онд 41 хувиар өсч байсан бол 2012 онд 26.5 хувиар нэмэгдсэн. Хадгаламжийн өсөлтийг валютаар авч үзвэл төгрөгийнх 19.5 хувьтай, гадаад валютынх 46.7 хувьтай байв (График 22). Төгрөгийн хадгаламж 2012 оны эхний гурван сард огцом буурснаас хойш банкны салбарт орж ирэх хадгаламжийн урсгал нэмэгдсээр байгаа нь банкны салбарын хүч чадалд итгэх итгэл сэргэсний илрэл байв. Өнгөрсөн оны таваас зургадугаар саруудад огцом нэмэгдсэнээс хойш гадаад валютын хадгаламжийн өсөлт тасралтгүй багасч, 2012 оны 10-р сараас эхлэн сөрөг утгатай болсон.

Банкны дотоодын хадгаламж, зээл 10-аас дээш хувийн хүүтэй хэвээр байна. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2011 онд 10.7 хувьтай байсан бол 2012 оны 12-р сарын байдлаар бага зэрэг өсч, 11.7 хувьтай болсон. 2012 онд инфляцийн түвшин өндөр буюу дунджаар 14 хувьтай байсныг тооцвол хадгаламжийн бодит хүү сөрөг утгатай байв. Банкуудын дотоодын аж ахуйн нэгжүүдэд олгож байгаа зээлийн гол эх үүсвэр нь хадгаламж байдаг тул хадгалаламжийн бодит хүү сөрөг утгатай байгаа нь хадгаламжийн өсөлтийг хязгаарлаж байна (График 23). 2013 оны эхний улиралд инфляци буурсан учраас хадгаламжийн бодит хүү бага зэрэг эерэг утга руу орсон. Мөн хугацаанд гадаад валютын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү харин 2011 онд 4.5 хувьтай байсан бол 2012 онд эцэст 6.1 хувьд хүрч, илүү хурдацтай өссөн. Цаашилбал, харилцагчдыг татахын тулд санал болгож байсан хадгаламжийн дээд хүү 10.2 хувиас 15.2 хувьд хүрсэн байна. Зээлийн жигнэсэн дундаж хүү мөн нэмэгдэх хандлагатай байсны дээр илүү ихээр өссөн. Тухайлбал, 2011 оны 12-р сард 15 хувьтай байсан болсон нэг жилийн дараа 18.2 хувьд хүрсэн. Дотоодын хадгаламж, зээлийн хүүгийн зөрүү 2012 оны 2-р сараас хойш 7 орчим хувиар нэмэгдсэн нь зээлийн эх үүсвэр хүрэлцэхгүй байсантай зарим талаар холбоотой.

Эдийн засаг, зээлийн өсөлт саарсан тул мөнгөний бодлого 2013 оны эхэн үеэс богино хугацааны зээлийн хүүг бууруулах замаар эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэх болсон. Монголбанк 2012 оны туршид мөнгөний хатуу бодлого баримталж, өсөн нэмэгдэж буй инфляцийг барих зорилго агуулсан. Тухайлбал, бодлогыг хүүг нэг хувиар өсгөн, 13.25 хувьд хүргэж, заавал байлгах нөөцийн хувь хэмжээг мөн

нэг хувиар нэмэгдүүлж, 12 хувь болгосон. Мөнгөний хатуу бодлогыг хоёр жилийн хугацаанд баримталсны эцэст Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2013 оны эхний дөрвөн сард бодлогын хүүг хоёр удаа бууруулсан. Тухайлбал, нэгдүгээр сард 0.75 хувиар бууруулж, 12.5 хувь болгосон бол дөрөвдүгээр сард нэг хувиар татаж, 11.5 хувь болгосон (График 24). Энэ нь мөнгөний бодлогын байр суурьт томоохон эргэлт гарч байгаа хэрэг юм. Үнийг тогтворжуулах хөтөлбөр хэрэгжсэнээр тодорхой үр дүн, нэн ялангуяа мах, шатахууны үнийн хувьд, гарна гэсэн хүлээлтийг үндэслэн бодлогын хүүг бууруулах шийдвэрийг гаргасан бололтой.

Төв банкнаас арилжааны банкуудад олгох зээлийн хэмжээ 2013 оны эхэн үеэс мөн ихээхэн нэмэгдсэн нь мөнгөний бодлогын байр суурьт гарсан өөрчлөлттэй нийцэж байна. Банкны салбарын Монголбанкинд төлөх ёстой өрийн үлдэгдэл 2013 оны эхний хоёр сард хоёр дахин гаруй нэмэгдэж, 1.1 их наяд төгрөгт хүрсэн. 2012 оны 12-р сард энэ үзүүлэлт 405 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан. Мөнгөний бодлогын эрх бүхий байгууллагын мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бодлого нь хоёр сувгаар хэрэгжиж байна. Нэгдүгээрт, Үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд өнгөрсөн хэдэн сарын хугацаанд Монголбанк арилжааны банкуудад их хэмжээний зээлийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгоод байна. Хөтөлбөр анх хэрэгжиж эхэлсэн үе буюу 2012 оны 11-р сараас 2013 оны 2-р сарын хооронд нийтдээ 230 тэрбум төгрөгийн зээлийг зорилтот салбаруудад олгожээ. Хоёрдугаарт, арилжааны банкуудын Төв банкинд төлөх ёстой өрийн үлдэгдэл нэмэгдсэн нь арилжааны банкуудын эх үүсвэрийг нэмж өгсөн хэрэг бөгөөд үүнийг Монголбанкны Засгийн газартай энэ оны хоёрдугаар сард байгуулсан Санхүүгийн зуучлалын гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар бизнесийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилго агуулсан. Гэрээнд заасны дагуу Монголбанк арилжааны банкуудад нийтдээ 850 тэрбум төгрөгийн (хоёрдугаар сард 400 тэрбум төгрөг, гуравдугаар сард 450 тэрбум төгрөг) хадгаламжийг 12 сарын хугацаатай байршуулсан. Бодлогын хүү буурсны зэрэгцээ мөнгөний нийлүүлэлт нэмэгдэх нь эдийн засгийн нийт эрэлтийг тэтгэх замаар инфляци саяхнаас буурах хандлагатай болсны эсрэг үйлчилж болзошгүй юм. Цаашид инфляцийн дарамт нэмэгдэхээс сэргийлэх үүднээс мөнгөний бодлогын эрх бүхий байгууллага мөнгөний бодлогыг сулруулж байгаа нь инфляци, зээлийн өсөлтөнд хэрхэн нөлөөлж байгааг сайтар хянах нь зүйтэй.

Мөнгөний нийлүүлэлт тасралтгүй саарсан боловч нөөц мөнгөний нийлүүлэлт тогтворгүй байв.

Хадгаламжийн өсөлт саарахтай зэрэгцээд зээлийн өсөлт мөн буурч, тогтвортой түвшинд очив.

График 21: Мөнгөний нийлүүлэлт (үлдэгдэлийн өөрчлөлт, хувь)





График 22: Банкны зээл, хадгаламжийн өсөлт (хувь, жилийн өөрчлөлт)



Эх сурвалж: Монгол улсын эрх бүхий байгууллагууд, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоолол.

Банкны зээл, хадгаламжийн хүү хоёр оронтой тоогоор илэрхийлэгдсэн хэвээр байгаа ч хадгаламжийн бодит хүү сөрөг байсаар байна.

График 23: Бодит хүү ба ХҮИ-ийн инфляци (хувь)



Мөнгөний бдлого 2013 оны эхэн үеэс богино хугацааны зээлийг хүүг бууруулах замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих чиглэлтэй болов.

График 24: Бодлогын хүү ба банкуудад олгосон төв банкны зээл



Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд санхүүгийн тогтвортой бус байдал заналхийлж байгаагийн дохио харагдахгүй байна. Гэхдээ учирч болох эрсдэлүүдэд байнга хянамгай хандах нь чухал хэвээр байн. Монгол улсын санхүүгийн захад банкны салбар давамгайлах байр суурьтай байдаг (өөрөөр хэлбэл, банкны бус салбар нийт санхүүгийн активын гурав хүрэхгүй хувийг эзэмшиж байна). Хөрөнгийн захын хэмжээ жижиг, үйл ажиллагаа нь бүрэн төлөвшөөгүй тул цөөн хэдэн томоохон банкууд аж ахуйн нэгж, иргэдийн санхүүжилтийн гол арга хэрэгсэл болж байна. 2012 онд арилжааны дөрвөн банк салбарын нийт зээлийн багцын 75 хувийг бүрдүүлж байсан. Тухайлбал, Хаан банк - 25.2 хувь, Худалдаа хөгжлийн банк - 21.8 хувь, Голомт банк - 20.5 хувь, ХасБанк – 9 хувь. Системийн ач холбогдолтой банкууд санхүүгийн салбарт чухал ач холбогдолтой байгаа учраас тэдгээрийн үйл ажиллагаанд байнгын мониторинг хийж, хяналт шалгалт явуулж байх нь чухал байна.

Хөрвөх чадварын эрсдэлд өртөх магадлал аажмаар нэмэгдэж байна. Хөрвөх чадварын эрсдэлийг хэмжих үзүүлэлт болох хөрвөх чадвартай актив, нийт активын харьцаа 2011 оны эцэст 23.4 хувьтай байсан бол 2013 оны 2-р сард 23.9 хувьтай болж, үл ялиг өссөн байна. Энэ үзүүлэлт сүүлийн үед сайжирсан хэдий ч хөрвөх чадвартай активын харьцаа 2010 онд хөрвөх чадварын нөөцийг бэхжүүлсэн үед 30 гаруй хувийн үзүүлэлттэй байснаас хойш байнга буурсаар ирсэн. Хөрвөх чадвартай актив, богино хугацаат өр төлбөрийн харьцаа 2011 оны дөрөвдүгээр улиралд 36.2 хувьтай байсан бол мөн багасч, өнгөрсөн оны мөн үед 34.2 хувьтай болжээ. Зээл, хадгаламжийн харьцаа 2013 оны 2-р сард 104 хувьд хүрч, 2012 оны 12-р сараас 87 хувь, 2010 оноос 70 хувиар тус тус өсчээ (График 25).


Чанаргүй зээлийн харьцаа 2010 оноос хойш буурсаар ирсэн. Чанаргүй зээл (хугацаа хэтэрсэн болон муу зээл), нийт зээлийн өрийн үлдэгдлийн харьцаа 2011 онд 7.2 хувийн үзүүлэлттэй байсан бол 2012 оны эцэст 5.8 хувь болж буурсан. 2009-2010 онд цаг агаарын байдал хүнд байсны улмаас онцгой хохирол амссан хөдөө аж ахуйн салбарын чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээ 2011 оны эцэст 19.1 хувьтай байсан бол 2012 оны сүүлийн улиралд 6.2 хувьтай болж хамгийн ихээр багассан (График 26). Нийт чанаргүй зээлийн багцын хэмжээ 2012 оны эцэст 330 тэрбум төгрөг байсан бол 2013 оны 2-р сард 305 тэрбум төгрөг болж буурсан. Үүнд Зоос, Анод гэсэн төлбөрийн чадваргүй болсон хоёр банкны чанаргүй зээлийн эргэн төлөлт үлэмж сайжирсан нь нөлөөлсөн.

Долларжилтын түвшин өндөр хэвээр байгаа тул санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл авчирч болзошгүй байна. 2012 оны эцэст гадаад валютын хадгаламж нийт хадгаламжийн дөрөвний нэгийг эзлэж байсан. Хямралын өмнө 30 гаруй хувийн үзүүлэлттэй байсантай харьцуулахад түвшин буурсан ч гэсэн банкны салбарын гадаад валютын өр төлбөрийн хувь хэмжээ өндөр байгаа нь санхүүгийн бэрхшээл тохиолдох нөхцөл төв банкны эцсийн зээлдэгчийн үүргээ үр дүнтэй гүйцэтгэх чадавхийг хязгаарлаж болзошгүй юм. Эдийн засаг сүүлийн үед эрчимтэй өсч, төгрөгөөр олгох зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа тул

санхүүгийн хяналт шалгалтын эрх бүхий байгууллагууд банкны салбарын гадаад валютын өр төлбөр, төгрөгийн активын хэмжээ ихээхэн зөрүүтэй байгаагаас эрсдэл учирч болзошгүй байдалд анхаарлаа хандуулах нь зүйтэй. Гадаад валютын хадгаламжийн хэмжээ 2013 оны 2-р сард Монгол улсын гадаад валютын цэвэр нөөцийн 25 орчим хувьтай тэнцэж байсан байна.


Зээл, хадгаламжийн харьцаа нэмэгдсээр 100 хувийг давав.

График 25: Хөрвөх чадварын эрсдэлийн үзүүлэлтүүд



Банкны салбарын чанаргүй зээл тогтвортой багасаж байна.

График 26: Чанаргүй зээл, нийт активын харьцаа (хувь)



Эх сурвалж: Монгол улсын эрх бүхий байгууллагууд, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоолол.

Шигтгээ 4: Монгол улсын хадгаламжийн даатгалын шинэчлэл

Банкин дахь хадгаламжийн даатгалын тухай хуулийг 2013 оны 1-р сарын 10-нд шинээр баталсан нь Монгол улсын санхүүгийн системийн хөгжилд чухал үйл явдал болж, хадгаламжийн даатгалын тогтолцоо бүрэн баталгааны хэлбэрээс хэсэгчилсэн даатгалын тогтцоолсонд шилжсэн юм. Хадгаламжийн даатгалын шинэ тогтолцоо бүрэлдэн бий болж, бүрэн хэмжээгээр ажиллаж эхэлснээр Хадгаламжийн даатгалын үйл ажиллагаа эрхлэгчдийн олон улсын холбооноос мөрдөхийг зөвлөдөг хадгаламжийн даатгалын орчин үеийн стандартуудад (Хадгаламжийн даатгалын оновчтой тогтолцооны үндсэн зарчмууд) илүү нийцэх болно.

Хадгаламжийн бүрэн баталгаа

Монгол улс 2008 оноос хойш хадгаламжийн бүрэн баталгааны тогтолцоотой байж, банкин дахь мөнгөн хадгаламжинд төрөл, хэмжээнээс үл хамаарсан төрийн баталгаа үйлчилсэн. Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын үр дагавар Монгол улсад тодорхой хэмжээгээр мэдрэгдсэн учраас хадгаламжийн бүрэн баталгааг хэрэгжүүлж эхэлсэн. 2008-2009 онуудад арилжааны хоёр хувийн банк төлбөрийн чадваргүй болж, эрх бүхий байгууллагын мэдэлд очсон. Тухайн үед иргэд банкны системээс хадгаламжаа татаж, зах зээл дээр нэмэлт донсолгоо үүсэхээс урьдчилан сэргийлэхэд зохих арга хэрэгсэл нь хадгаламжийн бүрэн баталгаа гэж үзсэн. Хадгаламжийн бүрэн баталгааг анхнаасаа түр зуурын арга хэмжээ болгож дөрвөн жилийн хугацаатай хэрэгжүүлж, 2012 оны 11-р сарын 25-нд хуулийн хүчинтэй хугацаа дуусгавар болсон.

Хадгаламжийн баталгааны тухай хуулийг 2008 онд батлахдаа банкууд Сангийн яаманд даатгалын хураамж төлөхөөр заасан боловч 2012 оны эцэст багахан хэмжээний хураамж төлөгдсөн байна. Үлдэгдэл хураамжийн талаар зарим банкууд Засгийн газартай маргаан үүсгэж, хараахан шийдвэрлээгүй байна.

Хадгаламжийн хэсэгчилсэн даатгалын тогтолцоо руу шилжих талаар

Эрх бүхий байгууллагууд хадгаламжийн хэсэгчилсэн даатгалын шинэ, орчин үеийн тогтолцоог бий болгох талаар 2010 оноос эхлэн нухацтай ажилласан. Тухайн үед Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг олон талт хамтын ажиллагааны санхүүгийн байгууллагууд зөвлөх үйлчилгээг зохион байгуулж өгч, ухагдахууныг шинээр бий болгож, хуулийн төсөл, журам зааврыг боловсруулахад туслалцаа үзүүлсэн. Монгол улс банкны хадгаламжийн даатгалын төлбөрийн хайрцаг буюу зөвхөн нөхөн төлбөрийг хариуцах төрлийн тогтолцоотой болохоор шийдсэн бөгөөд эрх мэдлийг бүрэн хэмжээгээр тогтоож өгсөн. Тухайлбал, банкны үйл ажиллагаа явуулах гэрчилгээ хүчингүй болсон буюу даатгалын тохиолдол гарсан нөхцөлд хадгаламжийн даатгалын байгууллага нь даатгагдсан хадгаламжийг нөхөн төлөх үндсэн үүрэгтэй. Банкны хяналт шалтгалт, төлбөрийн чадваргүй болсон банкны асуудлыг шийдвэрлэх үүрэг банкны салбарын зохицуулагч болох Монголбанкинд хадгалагдан үлдэнэ.

2013 оны 1-р сард шинээр батлагдсан хуулинд зааснаар Хадгаламжийн даатгалын корпораци гэж байгуулагдах бөгөөд энэ нь 100 тэрбум төгрөгийн дүрмийн сангай, хадгаламжийн даатгалын үндэсний байгууллага юм. Дүрмийн санг улсын төсөв, Монголбанкнаас тэнцүү хувааж гаргасан. Хадгаламжийн даатгалын дээд хэмжээ нь 20 сая төгрөг буюу 14,400 орчим доллар байна. Хадгаламжийн дундаж үлдэгдэлийн хэмжээ харьцангуй бага байгаа учраас⁶ хадгаламж эзэмшигч хувь хүмүүсийн үнэмлэхүй ихэнх буюу 99 гаруй хувь нь энэхүү даатгалд хамрагдах болно. Банкны хадгаламжийн задаргааг 2011 оны байдлаар авч үзвэл хадгаламжийн хэмжээгээр 31 орчим нь даатгалд хамрагдана. Хадгаламжийн нийт хэмжээ 2012 онд өссөн тул даатгалд хамрагдах хадгаламжийн хэмжээгээр (20 сая төгрөг) нийт хадгаламжийн үнийн дүнгийн 30 хүрэхгүй хувь нь хамрагдахаар байна. Ямартаа ч хадгаламжийн хэмжээгээр хамгийн багадаа 20 хувийг хамруулсан байна гэсэн ерөнхий зарчимтай⁷ нийцэх болно.

Банкин дахь Хадгаламжийн даатгалын тухай хуулинд зааснаар Хадгаламжийн даатгалын корпораци нь бүрэн

⁶ 2010 онд 800,000 орчим төгрөг.

⁷ Үндсэн зарчмууд зайлшгүй хамрагдах ёстой хувь хэмжээг тогтоодоггүй боловч үнэлгээний аргачлалын гарын авлагад дээд хязгаарыг тогтоохдоо дараах зүйлийг харгалзан үзэхийг зөвлөсөн байдаг. Үүнд: (1) жижиг хэмжээний хадгаламж эзэмшигч хувь хүмүүсийн ихэнх хэсэг бүрэн хамрагдсан байх (хадгаламжаа банкнаас татах хөшүүргийг зайлуулах) гэхдээ (2) нийт хадгаламжийн үнийн дүнгийн ихээхэн хэсэг хамрагдахгүй үлдэж, зах зээлийн сахилга батаас хамаарсан хэвээр үлдэх. Дэлгэрэнгүй мэдээллийг Санхүүгийн үйлчилгээний зөвлөлийн 2012 оны “Хадгаламжийн даатгалын тогтолцооны тойм: ижил түвшний үнэлгээний тайлан” болон Ulrich H. Klueh, David S. Hoelscher, Michael Taylor нарын 2006 оны судалгааны ажил “Хадгаламжийн даатгалын тогтолцооны хэлбэр, зохион байгуулалт, хэрэгжилт”, ОУВС Зарим судалгааны ажлууд 251-аас аяна уу. ОУВС-гийн судалгааны тайланд даатгал нь хамгийн багадаа нийт дансны 80 хувь, үнийн дүнгийн 20 хувийг хамрах ёстой гэсэн дүрмийг баримталсан.

хэмжээний эрх мэдэлтэй байна. Тухайлбал, банк тус бүрээр эрсдэлд суурилсан хураамжийн хэмжээг тогтоох, төлбөрийн чадвараа алдсан банкны хадгаламжийг шилжүүлэн авч байгаа банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг болно. Тухайн банкинд олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг тогтоохдоо хамгийн бага өртгийн шалгуурыг ашиглах эрхтэй. Эдгээр эрх мэдэл болон хуулийн зарим заалтыг хуулинд нийцүүлэн боловсруулах учиртай журам зааварт тодорхой тусгах шаардлагатай. Одоогоор хамгийн гол зорилт бол Хадгаламжийн даатгалын корпорацийг үүсгэн байгуулан ажилтнуудыг томилсны дараагаар холбогдох дотоод дүрэм журмыг боловсруулж, Монгол улсын санхүүгийн тогтвортой байдал, хамгаалалтын бүтцийн зайлшгүй чухал шинэ бүрэлдэхүүн хэсэг болгож үйл ажиллагааг нь эхлүүлэх явдал байна.

Эх сурвалж: Дэлхийн Банк.

Цаашид тулгамдаж буй сорилтууд: Эрдэсийн орлогын тогтвортой удирдлагын төлөө

Монгол улсын эдийн засгийн өсөлт өнгөрсөн хоёр жилд хоёр оронтой тоогоор илэрхийлэгдсэн ч гэсэн гадаад цочролд өртөх эрсдэлээс гадна ашигт малтмалаас хамаарах хамаарал нь нэмэгдэж байна. 2013 онд нэгдсэн төсвийн нийт орлогын 20 гаруй хувийг эрдэсийн орлогоос бүрдүүлж, эрдэс бүтээгдэхүүний экспорт нийт экспортод эзлэх хувь хэмжээ 90 хувиас давж гарах тооцоо байна. Нэг талаас эрдэсийн бус салбаруудын хүчин чадал сул, эдийн засгийн багтаамж бага учраас ашигт малтмалаас хамаарах хамаарал нэмэгдэх нь зайлшгүй юм. Ашигт малтмалын арвин их нөөцийг оновчтой ашиглан зарцуулж чадвал Монгол улсыг урт хугацаанд бүс нутагтаа хамгийн их хөгжин цэцэглэсэн улсуудын нэг болгох боломжтой. Гэхдээ байгалийн нөөцийн хишиг өөрийн гэсэн сорилтуудыг дагуулж байдаг. Эрдэсийн орлогоос улам бүр

хамааралтай болсоноор Монгол улсын эдийн засаг гадаад цочрол, эрдэс бүтээгдэхүүний зах зээлийн гэнэтийн тасалдалд өртөх эрсдэл нь ихэснэ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн хууль зэрэг нь батлагдсанаар төсвийн удирдлагын тогтолцоо тодорхой хэмжээнд бэхэжсэн хэдий ч өнгөрсөн хоёр жилийн төсвийн удирдлагыг харахад төсвийн бодлогын хүрээ хямралын өмнөх мөчлөг дагасан хэлбэрт эргэн орж байна. 2010 онд төсөв ДНБ-ий 0.5 хувьтай тэнцэх хэмжээний багахан ашигтай гарснаас хойш төсвийн тэнцэл үлэмж муудсаар ирлээ. Төсвийн тэнцэл 2011 онд 4.8 хувийн алдагдалтай болсон бол 2012 онд улам доройтож, 7 хувийн алдагдалтай гарч, сүүлийн арван гурван жилийн түүхэн дэхь хамгийн муу үзүүлэлт болов. Төсвийн тэнцэл доройтож байгаа нь зарлагын өсөлт орлогынхоос хамаагүй түрүүлж байгаагийн илрэл юм. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд төсвийн нийт зарлага 41 хувиар нэмэгдсэн бол орлого 27 хувиар өсчээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд төсвийн арвич хямгач зарлага, хуримтлалыг хөхүүлэн дэмжсэн байдаг хэдий ч төсвийн алдагдал 2011, 2012 онуудад эрдэс бүтээгдэхүүний үнэ унасан хямралын үеийнхээс хол давжээ.

Эдийн засгийн өсөлт эрчимтэй байх төлөвтэй, инфляци хоёр оронтой тоо руу дөхсөн байгаа энэ үед хэт мөчлөг дагасан төсвийн бодлого баримталсанаар эдийн засгийн байнгын бөгөөд тогтвортой өсөлтийн замналд эрсдэлд учирч болзошгүй байна. Дараахь эрсдэлүүд учирч болзошгүй. Үүнд:

- **Төсвийн жийрэг буюу хуримтлал хангалттай хэмжээгээр бий болоогүй байгаа учраас тэлэлт, агшилтын мөчлөгт өртөх эрсдэл нэмэгдэж байна.** Эрдэс бүтээгдэхүүний үнийн гэнэтийн савалгаа нь төсөвт ноцтой цочрол болж, эдийн засгийг хялбархан уналтанд оруулж болохыг 2008-2009 онуудын үйл явдал нотлон харуулсан. Төсвийн алдагдал ихээр хуримтлагдахтай зэрэгцээд төсвийн жийрэг болохуйц хуримтлал хангалттай бүрдээгүй байгаа учраас төсвийн эрх бүхий байгууллага эрдэс бүтээгдэхүүний зах зээл дээр үүссэн гэнэтийн цочролын эсрэг арга хэмжээ авах нөхцөл боломж нэлээд хязгаарлагдмал байна. Төсвийн орлого тасарч, зарлага санхүүжилтийг танаж зохицуулах амаргүй шийдвэр гаргах шаардлага үүсэх бөгөөд энэ нь эргээд эдийн засгийг улам хумих болно.
- **Улсын өр нэмэгдэж байгаа нь цаашид томоохон дарамт ачаалал үүсгэж болзошгүй юм.** Нэгдсэн төсвийн их алдагдалыг гадаад, дотоодын зээллэгээр санхүүжүүлсэн тул 2012 онд улсын өр огцом нэмэгдсэн. Тодруулбал, Хөгжлийн банкны бонд, Чингис бондыг амжилттай арилжаалж, хоёр тэрбум гаруй ам. долларын буюу ДНБ-ий 20 хувьтай тэнцэх хэмжээний асар их хөрөнгийг гадаад зээллэгээр авсан. Энэ гадаад зээлийг тав болон арван жилийн дараа эргэн төлөх эсвэл дахин санхүүжүүлэх тул ирээдүйн төсвийн өр төлбөрт нэлээд хамаатай юм. Зээлийн хугацаа дуусгавар болох үед төсвийн орлогыг зээлийн томоохон эргэн төлөлтөнд зарцуулах шаардлагатай болж, төсвийн орон зай айхтар хязгаарлагдах тул бусад зарлагын санхүүжилтээс хасагдана гэсэн үг юм. Хэрвээ төсвийн алдагдал, улсын өр оргилон нэмэгдэх энэхүү хандлага цаашид үргэлжилбэл, ирээдүйд авах зээлийн өртөгт мөн сөргөөр нөлөөлөх магадлалтай. Төсвийн гадуурх санхүүжилтийн арга хэлбэр, түүний дотор Хөгжлийн банк, барих, шилжүүлэх гэрээний дагуу төр-хувийн түншлэлээр хэрэгжиж буй төслүүдэд гаргаж өгсөн баталгаанаас үүдэлтэй болзошгүй өр төлбөр нэмэгдэж байгаа нь мөн цаашид төсөвт томоохон дарамт ачаалал үүсгэх болзошгүй юм.
- **Төсвийн хурдацтай өсөн нэмэгдэж байгаа зарлага засгийн газрын төлөвлөлт, хэрэгжилтийг хангах чадавхи, эдийн засгийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг түрүүлж байгаа бололтой.** Төсвийн зарлага санхүүжилтийн үр дүнд сайн чанарын автозам эсвэл цахилган станц барьж байгуулахад төлөвлөлтийг зөв зохистой хийж, барилгын ажлыг чанартай сайн гүйцэтгэсэн байх шаардлагатай. Дэд бүтцийн төслийн өртгийг үндэслэлтэй тооцоолох хэрэгтэй; ажил гүйцэтгэх, бараа үйлчилгээ нийлүүлэх гэрээг ил тод, өрсөлдөөнт зарчмаар байгуулсан байна; гэрээний

гүйцэтгэгчид тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, хөрөнгө нөөцтэй байж, ажлыг зүй зохистой гүйцэтгүүлэхийн тулд хяналтын тогтолцоо үйлчилж байх ёстой. Төсвийн санхүүжилтээс эхлээд чанартай автозам, бусад дэд бүтцийн байгууламжийг шинээр бүтээн байгуулах хүртэлх үе шатуудад эдгээр гол холбоосуудын аль нь ч одоогоор хангалттай сайн ажиллахгүй байна. Цаашилбал, Монгол улс бол мэргэжилтэй ажилчин, завсрын бүтээгдэхүүний (жишээлбэл, барилгын материал) хязгаарлагдмал нөөцтэй, нээлттэй жижиг эдийн засагтай орон юм. Улсын хөрөнгө оруулалт эдийн засгийн үйлдвэрлэх хүчин чадлаас давж, хурдацтай нэмэгдэхийн хирээр үйлдвэрлэлийн өртөг өсч, инфляцийг хөөрөгдөх болно.

- **Төсвийн удирдлагын загвар одоогоор “хурдан зарцуулах”-д чиглэж байгаагаас “үр ашигтай зарцуулах” руу шилжих зөвшилцөлд хүрэх нь энэ үеийн томоохон сорилт болоод байна.** Үүний тулд төсвийн зохицуулалтыг илүү оновчтой, зохистой болгож, урьдын тэлэлт, агшилтын мөчлөг дахин давтагдахаас сэргийлэн, засгийн газрын хөрөнгө зарцуулах чадавхи, эдийн засгийн шингээх хүчин чадалд нийцүүлэн төсвийн зарлага санхүүжилтийн өсөлтийг тогтоох хэрэгтэй. Төсвийн зохистой, тогтвортой хүрээг бүрдүүлэхэд төсвийн зарлага санхүүжилтийг дунд хугацаанд жигд хуваарилж, зарлагын өсөлтийг биелэгдэхүйц түвшинд хянан, төсвийн урьдчилан сэргийлэх хуримтлал үүсгэх нь эхний алхам болох учиртай. Эрдэсийн орлогоо оновчтой удирдан зарцуулж чадсан улсуудын туршлагаас харахад дунд болон урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн амжилтанд хүрэхэд урьдчилан сэргийлэх хуримтлалыг онцлон тэмдэглэсэн байдаг (Шигтгээ 4).
- **Төсвийн зарлага санхүүжилтийг эрдэсийн орлогын богино хугацааны савалгаанаас аль болох ангид байлгах нь зүйтэй.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон тусгай шаардлагуудыг хангаж, төсвөөс гадуурх санхүүжилтийн механизм ашиглахгүй байх нь ойрын хугацаанд хийж гүйцэтгэх ёстой ажил юм. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд төсвийн хүчтэй сахилга батыг тусгаж чадсан бөгөөд эрдэс нөөцийн орлогыг зохистой, үр дүнтэй удирдах суурийг бүрдүүлж байгаа юм. 2013 онд нэгдсэн төсвийн алдагдалыг бууруулах зохих төлөвлөгөө хэрэгжүүлж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд заасан дээд хязгаарт аль болох дөхүүлэн барих шаардлагатай байна. Цаашид хэрэгжүүлэх бусад арга хэмжээний тухайд засгийн газар, эдийн засгийн хөрөнгийг тохируулан зарцуулах чадавхи, хүчин чадал хязгаарлагдмал байгаа бодит байдалд нийцүүлэн нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах хэрэгтэй. Тухайлбал, (1) засгийн газрын улсын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй удирдан хэрэгжүүлэх чадавхи болон (2) барилгын салбарын шингээх хүчин чадал.
- **Эрдэсийн орлогоос хангалттай хэмжээний хуримтлал үүсгэж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахаас гадна зарлага санхүүжилтийг тохируулан зарцуулах чадавхид нийцүүлэн зохицуулах нь зүйтэй.** Монгол улсын эдийн засаг эрдэс баялгийн зах зээлийн гэнэт сүйрэлд өртөх байнгын аюулыг нүүрлэсэн байдаг. Хувийн хэвшилд олгож байгаа зээл нь мөн чанартаа мөчлөг дагасан байдаг бөгөөд төсвийн жийрэг хамгаалалтын үүрэг бол эрдэс бүтээгдэхүүний зах зээлийн бууралтаас үүдэлтэй гэнэтийн цочролын эсрэг арга хэмжээ авахад оршино. Зарцуулалтыг одоо хийж, эрдэс баялгаас ногдол ашиг хүртэх хүлээлтийг өдрөөс өдөрт өсгөх гэсэн улс төрийн дарамт шахалтыг даван туулах нь гол сорилт байх болно. Урьдчилан сэргийлэх хуримтлал бүрдүүлэх нь мөн орлого багатай иргэдийг дэмжсэн стратеги байдаг. Орлого багатай, эмзэг бүлгийн иргэдийг дэмжсэн нийгмийн халамжийн тогтолцоог бэхжүүлэхийн зэрэгцээ эдийн засагт нэлээд том уналт нүүрлэсэн үед төсвийн хөгжилд чиглэсэн зарлага санхүүжилтийг бууруулахгүй байхад төсвийн хуримтлалыг ашиглах боломжтой байдаг.


Шигтгээ 5: Хоёр улсын талаар товчхон: Эрдэсийн орлогоос хуримтлал амжилттай үүсгэж, ашигласан туршилага

Чили болон Ботсвана улсууд нь ашигт малтмалын нөөцийг зарцуулан ашиглах дарамт шахалтын эсрэг оновчтой удирдахад тулгардаг сорилт бэрхшээлийг амжилттай даван туулж чадсан шилдэг туршлага хэмээн олон улсад магтагдаж ирсэн. Энэ оны гуравдугаар сарын 20-21-ний өдрүүдэд Баялгийн сангийн олон улсын хурлыг Сангийн яам Дэлхийн Банктай хамтран Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Хурлын үеэр энэ хоёр улсын туршлагыг танилцуулж, байгалийн нөөцөөс хамааралтай хөгжиж буй улсуудын хувьд төсвийн удирдлагын зохистой хүрээ чухал ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглэсэн.

Чили улс бол байгалийн нөөцөөс хамааралтай бас нэг орон бөгөөд дэлхийн зэсний нийлүүлэлтийн гуравны нэгийг үйлдвэрлэдэг. Зэсийн экспорт 2011 онд нийт экспортын 55 хувийг бүрдүүлж байсан. Чили улс төсвийн сахилга батыг сайн мөрдөж ирсэн түүхтэй. Төсвийн хариуцлагын тухай хуулийг 2006 онд батлаж мөрдүүлснээр төсвийн сахилга батыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн зохицуулалт бий болсон. Төсвийн хариуцлагын тухай хуулинд төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэлийг тооцох зарчмыг тогтоож, төсвийн эх үүсвэрийг хуримтлуулж, удирдан зарцуулах журмыг тодорхойлж, Тэтгэврийн нөөцийн сан, Эдийн засаг, нийгмийн тогтворжуулалтын сан гэсэн хоёр баялгийн сан байгуулахаар заасан. Энэ хоёр сангийн хөрөнгийг гадаадад байршуулдаг байна. Төсвийн хариуцлагын тухай хуулийг мөрдөж ажилласны үр дүнд Чили улс 2004-2008 оны өндөр өсөлтийн жилүүдэд төсвийн үлэмж хэмжээний хуримтлалтай болсон. Төсвийн ашиг 2006, 2007 онуудад ДНБ-ий 7 хувиас давсан. Дэлхийн санхүү эдийн засгийн хямрал ид өрнөж байхад буюу 2008, 2010 онуудад Чили улс төсөвт нүүрлэсэн цочролын эсрэг төсвийн хуримтлалаа идэвхтэй зарцуулж, ДНБ-ий 4 гаруй хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай гарсан байдаг. Үүний үр дүнд Чили улс эдийн засгийн өсөлтөө хямралын өмнөх өндөр өсөлтийн түвшинд хадгалж чадсан юм.

Ботсвана улс бол байгалийн нөөцөөс хамааралтай, далайд гарцгүй жижиг орон юм. 1966 онд тусгаар тогтнолоо зарлах үед дэлхийн хамгийн ядуу орнуудын нэг байсан бөгөөд нэг хүнд ногдох ДНБ нь 284 ам. доллар, нийтдээ 12 км хатуу хучилттай автозамтай байсан. Гэвч очир эрдэнийн олборлолтоос орсон орлогоо үр дүнтэй удирдан зарцуулсны үр дүнд эдийн засгийн тогтвортой, өндөр өсөлтийг 50 жилийн хугацаанд хангаж чадсан бөгөөд одоо очир эрдэнийн экспорт нийт экспортын 80 хувь, дотоодын үйлдвэрлэлийн тавны нэгийг эзлэж байна. Ботсванын төсвийн бодлогын зарчим бол урсгал зарлагыг зөвхөн эрдэсийн бус орлогоор санхүүжүүлж, харин эрдэсийн орлогыг хөрөнгө оруулалтын санхүүжилтэнд зарцуулах эсвэл баялгийн сан болох Пула санд хуримтлуулахад оршиж байв. 1980-аад оны дундаас 2007-2008 оныг хүртэлх хугацаанд Ботсванын Засгийн газар Пула санд ДНБ-ий 10 хувьтай тэнцэх хэмжээний санхүүгийн хуримтлал үүсгэж чадсан. 2002-2003 онуудын эрдэс бүтээгдэхүүний зах зээлийн огцом уналт, 2008-2009 онуудын дэлхийн санхүү эдийн засгийн хямралын үеэр цуглуулсан хуримтлалаа зарцуулж, төсвийн алдагдалыг төвөггүй санхүүжүүлсэн. 2011 оны байдлар нэг хүнд ногдох ДНБ 8,000 гаруй ам. доллар болсон байна.

График 27: Төсвийн тэнцэл, ДНБ-ий харьцаа (хувь): Чили улсын жишээ



Эх сурвалж: Дэлхийн Банк.

График 28: Төсвийн тэнцэл, ДНБ-ий харьцаа (хувь): Ботсвана улсын жишээ



Эх сурвалж: Дэлхийн Банкны Баялгийн сангийн хурал, Ботсвана

улсын жишээ, Keith Jeffereis (2013).

Эх сурвалж: Дэлхийн Банк; Байгалийн нөөцөөр баялаг орнуудын макро эдийн засгийн бодлогын хүрээ, ОУВС, 2012 оны 8-р сар.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2009	2010	2011	2012	2013 төс.	2014 төс.	2015 төс.
Бодит салбар							
Үйлдвэрлэл, ажил эрхлэлт, үнэ							
Бодит ДНБ (хувь, жилийн өөрчлөлт)	-1.3	6.4	17.5	12.3	13.0	11.5	8.1
Аж үйлдвэрийн үйлдвэрлэл (хувь, жилийн өөрчлөлт)	-3.3	10	9.7	7.2	26.3	15.3	5.7
Улаанбаатар хотын ХҮИ (хувь, жилийн өөрчлөлт, дундаж)	1.9	14.3	9.4	14.2	11.5	9.0	8.0
Нийтийн салбар							
Нэгдсэн төсвийн зарлага (ДНБ-д эзлэх хувь)							
Нэгдсэн төсвийн орлого (ДНБ-д эзлэх хувь)	35.5	36.6	45.1	42.5	39.2
Нэгдсэн төсвийн тэнцэл (ДНБ-д эзлэх хувь)	30.3	37.1	40.3	35.5	35.1
Нэгдсэн төсвийн тэнцэл (ДНБ-д эзлэх хувь)	-5.2	0	-4.8	-7.0	-4.1
Эрдэсийн бус тэнцэл	-12.4	-10.0	-18.1	-18.1	-11.7
Улсын өр (ДНБ-д эзлэх хувь)	46.6	45.3	51.7
Төлбөрийн тэнцэл							
Барааны экспорт (сая ам.долл)							
(хувь, жилийн өөрчлөлт)	1,903	2,899	4,817.5	4,384.6
Барааны импорт (сая ам.долл)	-25	52.8	66.2	-9.0
(хувь, жилийн өөрчлөлт)	2,131	3,278	6,598.4	6,738.9
Урсгал дансны тэнцэл (сая ам.долл)	-32.3	53.8	101.3	2.1
(ДНБ-д эзлэх хувь)	-592.0	-886.7	-2,758.6	-3,215.3
Гадаадын шууд хөрөнгө оруулалт (сая ам.долл)	-12.9	-14.3	-31.0	-31.3
Гадаад өр (ДНБ-д эзлэх хувь) (2)	1,037.6	1,629.7	4,620.1	3,835.1
Гадаад валютын нөөц, цэвэр (сая ам.долл)	43.2	28.2	26.1	29.4
<i>Дараа оны бараа үйлчилгээний импортын сараар</i>	1,328	2,288	2,457.1	4,090.7
	4.0	4.2	4.9	5.8
Санхүүгийн зах							
Дотоод зээл (хувь, жилийн өөрчлөлт)							
Бодлогын хүү (хугацааны эцэст)	-9.33	26.69	75.8	-7.5
Ханш (төг/ам.долл, хугацааны эцэст)	10.00	11.00	12.3	13.25
Үйлчилж буй бодит ханш (хувь, жилийн өөрчлөлт, хугацааны эцэст, + ханшийн чангаралт)	1,443	1,257	1,395.4	1,392.1
МХБ-ийн ТОП 20 индекс (2000=100, хугацааны эцэст)	-16.6	28.2	-5.6	8.0
	1,229	2,931	4,059.0	3,443.9

Суурь үзүүлэлтүүд:

ДНБ оны үнээр (тэрбум төг)	6,591	8,414.5	11,087.7	13,944.2	17,172.7
----------------------------	-------	---------	----------	----------	----------	-----	-----

Эх сурвалж: Монголбанк, УСХ, Сангийн яам, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Хавсралт: Уул уурхайн салбарын төлөв байдал (2013 оны 3-р сар)⁸

Монголын уул уурхай

Монгол улс бол ашигт малтмалын нөөцөөр баялаг орон бөгөөд алт, зэс, уран, нүүрсний дэлхийн томоохон ордуудын зарим нь энд байдаг. 1920-иод оноос хойш цуглуулсан геологийн тоо баримт, өнөөдрийг хүртэл хийгдсэн хайгуулын ажлын үр дүнгээр ашигт малтмалын арвин их нөөцтэй болох нь тогтоогдсон хэдий ч нутаг дэвсгэрийн дөнгөж 15 хувьд газарзүйн зураглал хийгдсэн байна. Өнөөдрийн байдлаар Монгол улсад 80 орчим төрлийн ашигт малтмалын зургаан мянга гаруй орд газруудыг нээн илрүүлээд байна. Эдгээрийн дөнгөж дөрвөн зуугийнх нь нөөцийг тогтоож, үүний 160 орчим дээр нь одоогоор олборлолт явагдаж, нутаг дэвсгэрийн дөнгөж 17 орчим хувьд хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон байна (Шигтгээ 6). Монгол улсад одоогоор 200 гаруй гадаадын болон хамтарсан компаниуд уул уурхайн үйл ажиллагаа явуулж байна. Монголын хөрөнгийн биржийн мэдээгээр 2010 онд биржид бүртгэлтэй компаниудын 28 хувь нь уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байсан⁹. 2012 онд уул уурхайн салбарт 19,217 хүн ажиллаж байсан нь 2010 оноос 17.9 хувиар өссөн үзүүлэлт юм.

Уул уурхайн талаар Монголд өөр өөр байр суурь харагддаг, гэхдээ энэ салбараас орох орлого, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсээр байгаа. Үр өгөөж, нөлөөлөл хэрхэн хуваарилагдаж байгаа, хөдөөгийн Монголчуудын уламжлалт аж байдлыг алдагдуулж байгаа, тус улсад нийтдээ, нэн ялангуяа ТТ нүүрсний орд, ОТ зэс, алт, молибденийн орд зэрэг гол бүтээн байгуулалтууд явагдаж байгаа Говийн бүсэд хомс нөөц болох усны асуудлаас сэтгэл дундуур байдал үүсч байна. Засгийн газар стратегийн орд газруудад өндөр хувь эзэмшиж байна.

Монгол улсын хувьд дараах нөхцөлүүд хангагдсан байх нь шийдвэрлэх ач холбогдолтой. Үүнд: (1) уул уурхайн салбар байгаль орчин, нийгмийн хувьд тогтвортой байдлаар хөгжих; (2) уул уурхайн орлогыг үр ашигтай хураан, ил тодоор удирдан зарцуулж, бүтээмжтэй бүх салбаруудыг хүссэн хэмжээний өсөлтөнд хүргэх; (3) төсвийн ухаалаг удирдлага, төлөвлөлт, эдийн засгийн төрөлжилтийг хангах замаар баялгийн хараалаас зайлсхийх; (4) уул уурхайн үйл ажиллагаа нь эдийн засаг нийтдээ өсч, үндэсний хөгжлийн зорилтууд, түүний дотор дэд бүтэц, эрчим хүч үйлдвэрлэл, газрын тосны завсрын, төгсгөлийн шатны болон хоёрдогч түүхий эдийн салбарууд, үйл ажиллагааг оролцуулахад хангахад хувь нэмэр болох. Түүхээс харахад Африк, Азийн бүсийн хөгжиж буй орнуудад ашигт малтмалыг (эсвэл ой мод зэрэг байгалийн бусад нөөцийг) эдийн засгийн эргэлтэнд оруулах нь ядуурлыг бууруулахад ямар нэгэн холбоо хамааралгүй байдаг. Гэхдээ Австрали, Канад, АНУ, Өмнөд Африк, Персийн булангийн хэд хэдэн орнууд, Финлянд зэрэг улсуудын туршлагаас харахад засаглал, нөөц ашиглалтын ухаалаг бодлого, түүнийг хэрэгжүүлэх зорилтот хөтөлбөрийн тусламжтайгаар ядуурлын ерөнхий түвшинг бууруулахад нааштай нөлөөлөл үзүүлж болдогийг ойлгох нь чухал байна. Эдгээр улсууд нь байгалийн нөөцөөр эдийн засгийн өсөлтөө өдөөсөн хэдий ч зорилтот арга хэмжээ, бодлого авч хэрэгжүүлсний үр дүнд өргөн хүрээний өсөлтөнд хүрч, эдийн засгаа төрөлжүүлж, ядуурлыг бууруулж чадсан.

⁸ Уул уурхайн салбарын тухай энэхүү хэсгийг Дэлхийн Банкны Уул уурхайн ахлах мэргэжилтэн Екатерина Михайлова бэлтгэсэн. Эрдэсийн салбарын өнөөгийн байдлын тухай судалгааг Кейптаун хотод 2012 оны 2-р сард болсон Уул уурхайн Indaba жилийн уулзалтын материалыг үндэслэж хийв.

⁹ Үндэсний статистикийн хороо, 2012 он, 30-р хуудас; Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар, 2011b, 23-р хуудас; Дэлхийн Банк, 2011, 23-р хуудас).

Шигтгээ 6. Монгол улсын гол эрдэсийн илэрц

Алт (Au). Алтны ихээхэн нөөц бүхий арван газар байдаг. Алтны олборлолт 1990-2005 онуудын хооронд үлэмж нэмэгдэж, 2005 онд 5.9 тонн алт олборлож байсан.

Зэс, молибден (Cu-Au-Mo). Монголын Алтай, хойд, өмнөд хэсэгт газар зүйн гурван бүс байдаг. Одоогоор олборлолт үндсэндээ Эрдэнэтийн баяжуулах үйлдвэр дээр явагдаж байна. ОТ ордын олборлолт эхэлснээр зэсийн олборлолт үлэмж нэмэгдэж, Монгол улс дэлхийн томоохон зэс үйлдвэрлэгч болно.

Хайлуур жонш (CaF₂). Монголын хойд, төв, өмнөд хэсэгт хайлуур жоншны 600 гаруй ор газар, илэрц байдаг. Төв хэсэгт хамгийн том нөөц байдаг бөгөөд олборлолт идэвхтэй явагдаж байна. Монгол улс дэлхийд жонш үйлдвэрлэлээр тавдугаарт жагсадаг. Дэлхийн нийт олборлолтын дөрвөн хувийг үйлдвэрлэж, хүчиллэг болон металлургийн зэрэглэлийн жонш гаргаж байна.

Нүүрс (Co). Монголын төв, өмнөд хэсэгт нүүрсний илэрц олон байдгаас Улааннуурын сав газар хамгийн их нөөцтөйд тооцогддог. Тавантолгой, Ухаа худаг, Бортолгой, Овооттолгой, Хөшөөт, Алтай нүүрс зэрэг сайн чанарын коксжих нүүрсний орд газруудыг илрүүлсэнээр 2004 оноос нүүрсийг экспортлох боломж нэмэгдсэн. Нийт 160 тэрбум тоннын нөөцтэй гэж үздэг.

Газрын ховор элемент (REE). Алтай, Хэнтий, Хангай, зүүн өмнөд, өмнөд хэсэгт эдийн засгийн үр ашигтайгаар олборлох боломжтой нөөц илэрсэн байдаг. Хамгийн өргөн тархацтай, эдийн засгийн үр ашигтайд тооцогддог элементүүд гэвэл тантал, ниобий, итрий, торий, циркон юм.

Уран (Ug). Эдийн засгийн хамгийн их үр ашигтай орд газрууд зүүн бүсийн Дорнод, Гурванбулаг, Мардай, өмнөд бүсийн Хараатад байдаг. Үнэлэгдсэн нөөц нь **1.3 тонн** байгаагийн **62 тонн** нь батлагдсан. Estimated reserves to be **1.3 Mt**, of which **62 Mt** are proven. 1989-1993 онуудад Мардайн орд дээр ил уурхай ажиллуулж, уран олборлож байсан боловч одоогоор хаагдсан хэвээр байна.

Эх сурвалж: Mдendi тайлан, Эрдэс баялгийн хэрэг эрхлэх газар .

Монгол улсад нөлөөлж буй дэлхийн уул уурхайн чиг хандлага

Өнгөрсөн хорин жилд дэлхий дахин “уул уурхайн супер мөчлөг” гэгчийг үүсч хөгжихийг харсан. Ази, Латин Америк, Зүүн Европын зарим улсуудад аж үйлдвэрийн салбар хурдацтай өсөхтэй зэрэгцээд металл, эрчим хүчний ашигт малтмалын эрэлт нэмэгдсэн. Технологийн дэвшлийн ачаар үелэх системийн бараг бүх элементийн эрэлт хэрэгцээ өссөн. Алтны хувьд мөчлөгийн эсрэг мөн чанараа санхүүгийн зах дээр хадгалагдан үлдэж, үнийн өсөлт нь түүхэндээ байгаагүй хэмжээнд хүрсэн.

Түүхийн үүднээс авч үзвэл, эрдэс бүтээгдэхүүний үнэ өсөхтэй зэрэгцээд эрдэсийн хөрөнгө оруулалт татах гэж өрсөлдөж байгаа орнуудын дунд “ёроол хүртэлх тэмцэл” гэх зүйл үүсдэг байсан. Гэхдээ одоогийн супер мөчлөгийг илүү нарийвчилсан, нэгдмэл хандлага тодорхойлж байна. Өнгөрсөн хорин жилийн хугацаанд уул уурхайн салбар шинэ тутам хөгжсөн бараг бүх улсууд ашигт малтмалын хууль тогтоомжоо орчин үед нийцүүлэн батлаж, уул уурхайн салбарт өрсөлдөх чадвартай татварын орчинг бүрдүүлсэн (Шигтгээ 7). Мөн түүнчлэн, Олборлох салбарын ил тод байдлын санаачлагын зарчмуудыг хүлээн зөвшөөрч, уул уурхайн орлогын ил тод байдлыг сайжруулах зорилт тавьсан. Цаашилбал, хөрөнгө оруулагчдын геологийн эрсдэлийг бууруулах үүднээс улсын хэмжээнд геологи, гео-физик, гео-химийн судалгаа, зураг зүйг гаргаж, уул уурхайн кадастр, геологийн тоо баримтыг хариуцсан тусгай байгууллагыг шинээр байгуулах буюу бэхжүүлсэн байдаг. 1990-ээд онд уул уурхай шинэ тутам хөгжсөн улсад уул уурхайн салбарын засаглал хэрэгжиж байх нь онцгой тохиолдол байдаг байсан хэдий ч 2000 оноос хойш нэн ялангуяа уул уурхайн асар том төслүүдийн төлөө өрсөлдөж байгаа орнуудын хувьд энэ нь зайлгүй шаардлага болсон. Уурхай байрлаж байгаа улсуудын засгийн газар “уурхайн ашиглалтын хугацааны дараах амьдрал”-д анхаарлаа түлхүү хандуулж, энэ хүрээнд орлогын удирдлагын механизмыг бий болгон, хамтран ашиглах дэд бүтцийг бүтээн байгуулах ажлыг эрчимжүүлж, хүний капитал, эдийн засгийн төрөлжилтөнд хөрөнгө оруулж байна.

Шигтгээ 7. Дэлхийн уул уурхайн салбарын үндсэн шинж тэмдэг

- Эрдэс бүтээгдэхүүний зах зээл савалгаатай байх хандлагатай.

- Уул уурхайн компаниуд хэдэн жил өндөр ашигтай ажиллаж, тааламжтай байсан боловч эрдэс бүтээгдэхүүний супер мөчлөгөөс улбаатай дараах дөрвөн шахалттай тулгараад байна. Үүнд: өртөг өссөн (ажиллах хүч, түүхий эдийн өртөг), илүү ихийг нэхэж шаардсан хувьцаа эзэмшигчид (нэгж хувьцаанд ногдох ашгийг өсгөх шаардлага), уурхай ажиллаж байгаа улсын зүгээс тавих дарамт шаардлага өссөн (татвар, өөрийн хөрөнгө), уул уурхайн үйл ажиллагааны нөлөөнд өртсөн иргэдийн хүлээлт нэмэгдсэн.
- Дээрх дөрвөн шахалт үүссэн энэ нөхцөлд эрдэс бүтээгдэхүүний үнэ ялихгүй буурсан ч цэвэр газрыг шинээр ашиглах болох хуучин бохирдсон газрыг ашиглах төслүүдийг санхүүжүүлэх хөрөнгийн хуваарилалтыг эрс дахин үнэлэхэд хүргэж байна. Ашигт малтмалын сайн чанарын орд газруудыг илрүүлэхэд улам хүндрэлтэй болж, тийм газруудад хүрэхийн тулд уурхайчид илүү их хүч шаардсан орчинд орж ажиллаж байна. Гэхдээ эрсдэл нэмэгдсэн, ашиг багассан энэ үед хайгуулын зардлыг юуны түрүүнд танаж байна. Дараагаар нь орд газрын ашиглалтын хугацаа найдвар муутай орнуудад хэрэгжиж байгаа төслүүд рүү орно. Ингэснээр эрсдэл багатай төслүүд, түүний дотор одоогийн үйл ажиллагааг өргөжүүлэх төслүүд тэргүүлэх чиглэлтэй болж байна.

Эх сурвалж: Дэлхийн Банкны мэргэжилтнүүд, Уул уурхайн Indaba-н тайлан, Кейптаун хот, 2013 оны 2-р сар.

Засаг төр, хөрөнгө оруулагч, ард нийтийн дунд үр өгөөж, эрсдэлийн шударга хуваарилалтыг тэнцвэржүүлэх нь чухал болохыг олон улсын туршлага онцолж байна. Зах зээлийн хувиа хадгалж үлдэхийн төлөөх улс болон уул уурхайн томоохон компаниуд хоорондын өрсөлдөөн ширүүн хэвээр байгаа бөгөөд одоо үед байгалийн нөөцийн хосгүй боломжтой байлаа гээд тухайн улс орон ойрын болон дунд хугацаанд хөгжин цэцэглэх баталгаа болохгүй болсон. Иймд одоогийн супер мөчлөгийн үргэжлэх хугацаа нь илүү тодорхой эрэлт шинээр эхлэхээс гадна өнөөгийн тодорхой бус төлөв байдлын улмаас эрдэс бүтээгдэхүүний олборлолт ойрын хугацаанд хэдий хэмжээгээр багасахаас хамаарч байна. Барклэйс Капитал компанийн тооцоогоор эрэлтийн өсөлт бодитоор нэмэгдэхээс өмнө эрдэс бүтээгдэхүүний үйлдвэрлэл дэлхийн хэмжээнд хурдацтай хэвээр өсөх тул эрдэс бүтээгдэхүүний үнэ буурах болно (Шигтгээ 8). Одоогоор хүлээгдэж байгаа төслүүд нь ихэнхдээ ашиглалтанд орох урт хугацаатай төслүүд байгаа бол уул уурхайн компаниуд олборлолтын хүчин чадлаа нэмэгдүүлэх, олборлолт эхлэхэд бэлэн төслүүдээ хэрэгжүүлэх замаар ойрын хугацаанд олборлолтоо өсгөж, бэлэн мөнгөний эх үүсвэртэй болохыг хүссэн хэвээр байгаа судалгааг Барклэйс энэхүү төсөөлөлд үндэс болгосон.

Шигтгээ 8. Гол түүхий эдийн үнийн сүүлийн үеийн өөрчлөлт

- **Алт:** Үнэ сүүлийн үед нэлээд тогтвортой өндөр байсан нь зардал үлэмж нэмэгдсэнийг үл харгалзан ашгийн түвшингээ хамгаалж үлдэхэд хангалттай байв.
- **Зэс:** Алтыг бодвол илүү савалгаатай байсан хэдий ч өндөр эрэлтийг хангахуйц нийлүүлэлт шинээр гарч ирэхэд төвөгтэй байгаа нь зэсийн үнэн дээр харагдаж байна.
- **Овор ихтэй эрдэс бүтээгдэхүүн:** Овор ихтэй эрдэс бүтээгдэхүүн, нэн ялангуяа төмрийн хүдэр, нүүрсний үнэ БНХАУ-ын эдийн засагт гарах өөрчлөлтүүдээс онцгой хамааралтай байсан бөгөөд одоо нөхцөл байдал илүү удаан хугацаанд ашиглагдах төслүүд хэрхэн шийдэгдэхээс хамаарч байна. Эсрдэлтэй, сорилт дагуулсан орчинд хэрэгжиж буй томоохон, дэд бүтцээс хамааралтай, ашиглалтанд орох урт хугацаатай төслүүдийг цуцалж, дэд бүтцэд холбогдсон бөгөөд илүү сайн ойлголттой орчинд ажиллаж байгаа уурхайг өргөжүүлэхээр шийдвэрлэж болно.

Эх сурвалж: Дэлхийн Банкны мэргэжилтнүүд, Уул уурхайн Indaba-н тайлан, Кейптаун хот, 2013 оны 2-р сар.

Тэгэхлээр компаниудын ойрын хугацаанд олох бэлэн мөнгөний нэмэлт эх үүсвэрийг нэмэгдсэн зардлыг санхүүжүүлэх, ногдол ашиг төлөх, төр засгийн өмнө хүлээсэн татварын үүргээ биелүүлэх, ард иргэдэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх, эсвэл уурхайн шинэ бүтээн байгуулалтын алинд нь зориулах вэ гэдэг нь том асуулт болно. Хэрвээ уурхайг шинээр байгуулах хөрөнгө оруулалтыг бусад хэрэгцээг хангахад зориулвал шинэ уурхайн хөрөнгө оруулалт ерөнхийдөө бодож байснаас хэсэг хугацааны дараа бодит ажил хэрэг болж магадгүй. Өнөөдөр нөхцөл байдал нарийн төвөгтэй болсныг үл харгалзан, ашигт малтмалын салбарын төлөв байдал урт хугацаанд эрчтэй байгаа бөгөөд дэлхийн эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч шинэ тутам хөгжиж буй эдийн засагт явагдаж байгаа аж үйлдвэрийн хөгжилд байгалийн нөөцийн эрчим нэмэгдэж, түүн дээр суурилсан эрэлтийн суурь чиг хандлага нь эрдэс бүтээгдэхүүний үнийг урт хугацаанд өндөр түвшинд барих төлөвтэй байна. Энэхүү таамгийг МакКинзи (*Байгалийн нөөцийн хувьсгал 2011*) болон Чатам Хаус

(Байгалийн нөөцийн ирээдүй 2012) гэсэн судалгааны ажлууд бататгаж байна. Ашигт малтмалын нөөцийн зэрэгцээ нөөцийн хоосрол, ховор байдал, бусад газруудыг ашиглахад саад бэрхшээлтэй байх нь хөрөнгө оруулалтыг татсан хэвээр байх болно.

Монгол улсад ямар учир холбогдолтой болох тухай

Овор ихтэй эрдэс бүтээгдэхүүний хувьд бизнесийн орчин, дэд бүтцийн шийдлээс олон зүйл хамаарна. Ашигт малтмалын тухай хуулийн төслийг 2013 онд шинээр боловсруулж байгаатай холбоотойгоор олон хөрөнгө оруулагч нар хөрөнгө оруулалтын шийдвэрээ хууль батлагдахыг хүлээж хойшлуулах магадлалтай. 2010 оноос хойш хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг зогсоож, урьд олгогдсон тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглосон нь хайгуулын үйл ажиллагаанд ихээр нөлөөлж, шинэ төслүүд хэрэгжихийг хойшлуулах нь гарцаагүй. Уул уурхайн үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулахад геологийн нааштай үзүүлэлтийн дараа ашиглалтын найдвартай байдал нь хамгийн чухал хүчин зүйлүүдийн нэгд тооцогддог. Иймд уул уурхайн салбарын тогтвортой хөгжил, өсөлтийг хангахад уул уурхайн кадастрын үйл ажиллагаа хэвийн явагдаж, тусгай зөвшөөрөл олгох ил тод, үзэмжээр шийдэгддэггүй журам мөрдөгдөж байх ёстой. Монгол улс томоохон зах зээлийн зэргэлдээ оршиж, ашигт малтмалын хосгүй их нөөцтэй, тогтвортой байдал үндсэндээ хангагдсан нь хүчтэй давуу тал болох хэдий ч нөөцийг ашиглах шийдвэр гаргахад хөрөнгө оруулагчид ашиг орлого олж, олсон ашгаа өөрийн орон руу шилжүүлэн авах боломж нь зонхилох шалгуур болдог. ОТ эсвэл ТТ-н хэмжээний дэвшилтэт үйл ажиллагаанууд цааш үргэлжлэх нь гарцаагүй. Гэхдээ бизнесийн орчин илүү тааламжтай болтол олон тооны шинээр эхлэх төслүүдээс татгалзах эсвэл “нөөцөд” үлдэх эрсдэлийг дутуу үнэлж болохгүй юм. Уул уурхайн үндэсний компаниудын хувьд ойрын жилүүдэд санхүүжилт, чадавхи саад бэрхшээл хэвээр байх болов уу.